

ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ

УИХ-ын 2008 оны сонгуулийн дүнд байгуулагдсан Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн эхний 100 хоногийн үйл ажиллагааны тайлангаа тоймлон танилцуулж байна.

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн томоохон асуудлуудыг шийдвэрлэв. Засгийн газар өнгөрсөн хугацаанд ажлын болон ажлын бус өдөр, цагийг үл харгалзан өндөр ачаалалтай ажиллаж, 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж батлуулав. Түүнчлэн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн томоохон асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Тухайлбал:

- стратегийн орд газруудыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр шийдвэрийн төсөл санаачилж, УИХ-аар хэлэлцүүлснээр Тавантолгойн коксжих нүүрсний орд газрын 51, Оюутолгойн зэс, алтны орд газрын 34-өөс доошгүй хувийг Монголын тал эзэмших нөхцөлтэйгээр Хөрөнгө оруулалтын гэрээг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хийх тогтоолыг УИХ-аар батлууллаа. Ингэснээр хэдэн жил яригдаж, удтал хүлээлгэсэн ашигт малтмалын орд газруудыг ашиглаж, түүнээс олох ашгаас иргэддээ хувь хүртээх зорилт хэрэгжих нөхцөл бүрдэв;
- санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргах хуулийн төслийг боловсруулан, УИХ-аар батлуулав;
- иргэн бүрт 1.5 саяас доошгүй төгрөгөөр үнэлэгдэх дэмжлэг үзүүлэх асуудлыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган дэс, дараатай шийдэхээр ажиллаж байна. Засгийн газрын хуралдаанаар дээрх дэмжлэгийг хэрхэн олгох асуудлыг хэлэлцээд хувьцаа, бонд, боловсролын болон эрүүл мэндийн карт, бэлэн мөнгө, нийгмийн даатгалын шимтгэл, нэрийн данс зэрэг хэлбэрээр олгох хувилбаруудыг сонгон судалж байна;
- дэлхийн санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлэх асуудлыг хугацаа алдалгүй анхааралдаа авч, энэ талаар Ажлын хэсэг байгуулан, тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллав. Тэвчиж болохуйц зардлыг хэмнэх, түүний дотор төрийн болон төсөвт байгууллагуудад үрэлгэн зардлыг бууруулах, үүний хамт хөрөнгө оруулалтын зардлыг багасгахгүй байх зарчмаар 2009 оны улсын төсвийг боловсруулан батлуулав;
- “Атрын гурав дахь аян”-ы гарааны жил 2008 онд сүүлийн жилүүдэд авч байгаагүй их хэмжээний ургац хурааж, тариалан эрхлэгчдээс 100.0 мянган тонн улаан буудай худалдан авч нөөц бүрдүүлэв. Махны нөөц бүрдүүлэхэд зориулан 4.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилав. Ингэснээр гурил, мах, хүнсний ногооны хэрэгцээнд хомсдол үүсэхгүй, үнэ өсөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж чадлаа;
- нийслэлийн нийтийн тээврийн талаар Засгийн газар тогтоол гаргаж, нийтийн тээврийн тасалбарын үнийг нэмэгдүүлэхгүй байх, 2009 оны Цагаан сараас өмнө нийтийн тээвэрт том оврын автобусны паркийн шинэчлэлт хийж эхлэхээр шийдвэрлэв.

Цомхон, зардал хэмнэсэн бүтцийг бүрдүүлэхээр чармайж байна.

Засгийн газрын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт цомхон, илүү шат дамжлагагүй, чиг үүргийн давхардалгүй байх зарчмыг баримтлан яамдын тоог цөөрүүлж 11 яам байгуулан зохион байгуулалт, байршлыг тодорхойлон үйл ажиллагааг нь төвхнүүлж байна. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг

боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж байна. Төсөлд тохируулагч 11, хэрэгжүүлэгч 31 агентлаг байхаар тусгасан бөгөөд өмнөх бүтцээр нийт 65 агентлаг байсныг цөөрүүлснээр 330 орон тоо, 2.4 тэрбум төгрөг хэмнэх тооцоо гарч байгаа юм. УИХ-аар энэ асуудал батлагдмагц яамд, агентлагийн бүтцийн асуудал цогцоороо шийдвэрлэгдэх юм.

Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгтгэн боловсруулсны дээр аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын бүтцийн талаар ерөнхий чиглэл гаргаад байна. Мөн яамдын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох, ажлын ачааллыг нягтруулж, хариуцлагыг өндөржүүлэх, илүү шат дамжлагагүй байх зарчим баримтлан ажиллаж байгаагийн зэрэгцээ төсвийн сахилгыг чанд мөрдөх, үргүй зардал гаргахгүй байх талаар харьяа агентлаг, байгууллагуудад тодорхой үүрэг даалгавар өгөн ажиллаж байна.

Орон нутгийн сонгуулийн үр дүнгээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг томилж, Монгол Улсын Ерөнхий сайд батламжлав.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарыг хамруулан ажил хэргийн уулзалт, сургалт-семинарыг зохион байгуулж байна. Энэ семинарын гол зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны байгууллага, орон нутгийн зүгээс анхаарах асуудлын талаар зөвлөлдөн ярилцаж, харилцан хүлээх үүрэг, хариуцлагаа тодорхойлох /Засгийн газрын гишүүд аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд гэрээ байгуулах/-д чиглэгдэж байна.

Төрийн алба иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байх, хүнд сурталгүй, хариуцлагатай байхыг чухалчилж байна. “Нээлттэй хаалганы өдөр”-ийг орон даяар зохион байгуулж, уг арга хэмжээний хүрээнд иргэдээс нийтдээ 90,0 гаруй мянган санал, хүсэлт хүлээн авч, 900 орчим уулзалт, хурал, цуглаан хийж, 120,0 гаруй мянган хүн хамрагдаж, 1700-аад хүн үг хэлж санал бодлоо илэрхийлсэн байна. Энэ үеэр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг цаашид Засгийн газрын бодлого, шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газар төрийн бус байгууллага /ТББ/, иргэний нийгэмтэй хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн бэхжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. Тухайлбал, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэдний төлөөллийг шийдвэр гаргах бүтцийн бүрэлдэхүүнд оролцох боломжийг бүрдүүлсний дээр ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлж болох 21 ажлын жагсаалтыг Байгаль орчны сайдын тушаалаар батлаад байна. Мөн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан “Ядуурлыг бууруулахад төр, төрийн бус байгууллагын түншлэл” уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлээ тогтлоо. Эрдэс баялаг, эрчим хүчний сайд бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүндээ хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оруулсан байна. Түүнчлэн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн 24 төрийн бус байгууллагаар 153 ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулав. Энэ бүхэн нь төрийн байгууллагын ачааллыг багасгах, бодлого боловсруулахад мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Төрийн албыг цалгардуулахгүй байх, элдэв сургалт, семинарт оролцох нэрээр үндсэн ажлаасаа олон хоногоор хөндийрч томилолтын үргүй зардал их гаргадаг байдлыг таслан зогсоох үүднээс орон нутгийн

засаг захиргааны байгууллагын удирдах ажилтнуудыг Улаанбаатарт зохиогдох сургалт, семинарт оролцох асуудлыг журамлаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэгдсэн хуваарь гарган хяналт тавьж байхаар болов. Түүнчлэн төрийн бус байгууллагын шугамаар зохион байгуулах арга хэмжээнд төсвийн зардлаар оролцохыг хориглож, гадаад оронд сургалт семинарт оролцохдоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зөвшөөрөл авч, томилолтын үр дүнг тайлагнаж байхаар тогтоов. Энэ шийдвэр сумдын удирдлагуудад ч хамаарах бөгөөд тэдний дотоод, гадаад албан томилолтын жилийн хуваарийг аймгийн Засаг дарга батлан мөрдүүлж байх юм.

Засгийн газар ард иргэдийн амьдралд нэн тэргүүнд шаардлагатай байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх асуудлын хүрээнд эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт болон байгалийн баялгийг ашиглахтай холбогдсон эрх зүйн орчинг шинэчлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж байна. Түүнчлэн эдийн засаг, нийгэм, цаг үеийн тулгамдсан олон чухал асуудлыг тухай бүр нь шийдвэрлэн ажиллахыг чармайж, тодорхой арга хэмжээг авч байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт

Иргэдэд үзүүлэх дэмжлэг. Стратегийн болон томоохон орд газруудыг ашиглаж олсон орлогоос иргэн бүрт 1.5 саяас доошгүй төгрөгөөр үнэлэгдэх дэмжлэг үзүүлэх асуудлаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэ асуудлын хүрээнд “Стратегийн болон томоохон орд газруудыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах, ашиг, орлого бүрдүүлэхтэй холбоотой харилцааг “Хуримтлалын сан” бүрдүүлж зарцуулах хэлбэрээр тусгайлан хуульчилж зохион байгуулах, “Хуваарилах, түгээх арга, хэлбэрийн хувьд нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан оновчтой байх” зэрэг хувилбарыг гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дахин боловсруулалт хийж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гурав дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300,0 мянган төгрөг олгох”, “Алдарт эх II одонтой эхэд 500.0 мянган төгрөг, Алдарт эх I одонтой эхэд 1.0 сая төгрөгийн тэтгэмжийг жил бүр олгох” зорилтыг хангахтай холбогдсон тооцоо судалгааг хийж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Ахмад настны нийгмийн хамгаалал. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. Уг төсөлд ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/- т сард нэг удаа мөнгөн тусламж үзүүлэхээр тусгав. Хууль батлагдсанаар 2008 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ахмад дайчдад сар бүр 200 000 төгрөгийн мөнгөн тусламж олгох бөгөөд энэ арга хэмжээнд шаардагдах 1089.0 сая төгрөгийг 2008 оны төсвийн тодотголд тусгаад байна. Мөн хуулийн өөрчлөлттэй холбогдон 2009 онд шаардагдах 4,3 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгав.

“Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 170 дугаар зарлигт “Ахмад дайчдад орон сууц олгох, эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох”-оор заасны дагуу ахмад дайчдын судалгааг гаргав. “Ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламжийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын

тогтоол, “Ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгох журам”-ын төслийг боловсруулаад байна.

“Нийгмийн эмзэг бүлгийн хүн амд хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлав. Энэ хүрээнд хүнсний бүтээгдэхүүний үнийн өндөр өсөлтөөс шалтгаалсан эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүнсний нөхөн олговор олгох замаар орлого багатай өрхийн хүн амын хоол, тэжээлийн дутлыг бууруулах, нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах ажлыг хоёр үе шаттайгаар 2012 он хүртэл хэрэгжүүлэх юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлэхээр тус банктай хэлэлцээр байгуулж, хэлэлцээрийн хүрээнд Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг байгуулаад байна.

Орон гэргүй, хараа хяналтгүй, тэнэмэл амьдралтай хүүхдүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудын ажил хэргийн уулзалт зохион байгуулж, цаашид салбар дундын уялдаа холбоотой, байнгын үйл ажиллагаатай ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гаргаж ажиллахаар тогтлоо.

Нийгмийн даатгал. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан нийгмийн даатгалын ажилтнуудын бүсчилсэн зөвлөгөөнийг үе шаттайгаар зохион байгуулав. Зөвлөгөөнд нийт 950 орчим ажилтан, нийгмийн даатгалын байцаагчид хамрагдаж, эрх зүйн шинэчлэлт, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг хэлэлцэж, ажлын чиглэлийг тогтов.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулах”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой нягт уялдуулж, хөрөнгө оруулалт, тэтгэвэр тэтгэмж, зээл тусламжийн талаархи хууль тогтоомжийг хянаж нийцүүлэх” зэрэг чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажиллах хүч гадаадаас авах бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулах талаар холбогдох яамд ажил хэргийн уулзалт зохион байгуулж, хамтран хөтөлбөр боловсруулаад байна. Хөтөлбөр нь гадаадаас авах ажиллах хүчний тоог багасгах, үүний тулд үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшил, ур чадварыг нь дээшлүүлэх, ялангуяа үйлдвэрлэл дээрх сургалтыг салбарын яамд хамтран зохион байгуулах, ажилгүй, эмзэг бүлгийн иргэд, ажлын дадлага туршлагагүй залуучуудыг орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх, оюутан суралцагчдад сургуулиас ажилд шилжих, аж ахуй бизнес эрхлэх чиг баримжаа олгох, залуу малчдад малын ашиг шимийг сайжруулах, мал маллагааны орчин үеийн арга технологи, фермерийн болон өрхийн аж ахуйгаа удирдах санхүү, орлогын эх үүсвэртэй болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэх юм. Тухайлбал, Байгаль орчны чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл хэрэгт олон нийтийн оролцоог хангах зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхийн олон улс орнуудад хэрэгжүүлдэг “Ногоон ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулаад байна.

Залуу малчдад малын ашиг шимийг сайжруулах, мал маллагааны орчин үеийн арга технологи эзэмшүүлэх сургалт явуулах, Малчдын аж ахуй

эрхлэлтийг дэмжих 2007 оны туршилтын хөтөлбөрийг үргэлжлүүлэн өргөтгөх арга хэмжээг зохион байгуулахаар хөтөлбөрийн төсөл боловсруулав. Мөн “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” туршилтын хөтөлбөрийн төсөл боловсруулж байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан нийт 9049 хүн бүртгэж, 12 дугаар сарын дундуур солонгос хэлний шалгалтад хамруулахаар бэлтгэл ажлыг хангав.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулсан гурван талт хэлэлцээг 2008 оны 10 дугаар сард зохион байгуулав. Хэлэлцээний үеэр “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ялгавартай тогтоох”, “Ажилчдыг үнэгүй хоолоор хангах, унааны хөлсийг нь тухайн үйлдвэр байгууллага бүрэн хариуцах хяналтын ба урамшууллын механизм бий болгох”, “Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүр төсвийн багц дотроо багтаан зохих эх үүсвэрийг бий болгосны үндсэн дээр боловсрол, эрүүл мэндийн салбарын болон төрийн бусад албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар салбарын ҮЭ-ийн холбоодтой хамтран хэлэлцэж нэмэгдүүлэх” чиглэлээр 2007-2008 оны улсын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулав.

Нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөхөд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн оролцоог хангах зорилгоор “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар-Хэвлэл мэдээллийн оролцоо” сэдэвт уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад телевиз, радио, сонины 46 сэтгүүлч, зураглаач нар оролцов. Уулзалтын үеэр “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн оролцоо, хамтын ажиллагаа”, “Хүн амын болон нийгмийн хамгааллын талаарх бодлого, түүний хэрэгжилт ба цаашдын зорилт”, “Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн салбарын өнөөгийн байдал”, “Нийгмийн даатгалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” зэрэг сэдвээр мэдээлэл өгч, харилцан санал бодлоо солилцсон нь салбарын ил тод байдлыг хангахад үр дүнтэй ажил боллоо.

Нээлттэй хаалганы өдрөөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд ажил олгогч байгууллагуудаас 3789 байрны захиалга хүлээн авч, нийт 1462 ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлснээс нийслэлд 567 хүн хамрагдлаа. Шинээр 371 ажлын байр бий болж, жижиг зээлд 261 хүн хамрагдахаар хүсэлт гаргасныг шийдвэрлэв. Говь-Алтай, Сүхбаатар, Төв аймаг, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт нийтийг хамарсан ажилд 142 хүнийг бүртгэн эрхийн бичиг олгож, хөдөлмөр эрхлээгүй 814 иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулахаар бүртгэв. Энэ өдөр халамжийн үйлчилгээний чиглэлээр тэтгэвэр, тэтгэмжид 4898 хүн хамрагдсан байна.

Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих хүрээнд хэрэгжүүлж буй олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг үр өгөөжтэй болгох, уялдааг хангах зорилгоор төсөл, хөтөлбөрүүдийн удирдах ажилтнуудын уулзалтыг зохион байгуулав. Энэ үеэр төслийн үр өгөөж, ач холбогдол, хувь нэмрийг үнэлэх, үүний тулд нэг зорилго чиглэлтэй, өөр өөр салбарт хэрэгжиж буй төслүүдийг бодлого, үйл ажиллагааны хувьд зангидаж, үр дүнг нэгтгэн тооцож, нэгдсэн мэдээлэлтэй байх, цаашид хамтарч ажиллахаар ярилцав.

НҮБХХ-ийн техникийн туслалцаа, дэмжлэгээр хэрэгжүүлэхээр “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны нээлттэй байдлыг дэмжих нь” төсөл боловсруулав. Төслийн зорилго нь тус яамны шийдвэр гаргах болон бусад үйл ажиллагааг ил тод байх зарчим, чадавхийг хөгжүүлж, мэдээлэл чөлөөтэй авах, санал өгөх, иргэдийн хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Хүүхдийн хамгааллын талаар. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц батлагдсан 11 дүгээр сарын 20-ны өдөр буюу “Хүүхэд хамгааллын өдөр”-ийг угтаж нэг сарын ажил зохион байгууллаа. Энэ хүрээнд 40 мэргэжилтэн хүүхэд хамгааллын сургагчаар, өсвөрийн сэтгүүлчдийн клубээс 10 сэтгүүлч хүүхэд хамгааллын сэтгүүлчээр бэлтгэгдсэн. Нийт 30.0 мянга орчим хүн хүүхэд хамгааллын ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцож хүүхэд хамгааллын талаар тодорхой ойлголттой болов.

2008 оны 7-р сарын 1-ний өдөр болсон үймээн самууны үеэр баривчлагдан хохирсон насанд хүрээгүй хүмүүс болон нас барсан иргэдийн үр хүүхдийг хамгаалах, тэдэнд сэтгэл санааны болон бусад шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр 461-р хорих ангид баривчлагдан саатуулагдсан хүүхдүүдтэй 5 удаагийн уулзалт ярилцлага хийж, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, дулаан хувцас, ариун цэврийн хэрэглэл, ном, хэвлэл зэрэг наад захын шаардлагатай туслалцаа үзүүллээ. Нийслэлийн шүүх болон 4 дүүргийн шүүхээс хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүүхдүүдийн мэдээллүүдийг цаг тухай бүрт цуглуулж эцэг эхчүүдтэй нэг бүрчлэн уулзав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан “Хамтдаа хөгжицгөөе” Үндэсний II чуулганыг зохион байгуулав. Чуулганд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид, тэдгээр хүүхдүүдийн төлөө ажилладаг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын төлөөлөл болсон төв, орон нутгийн 500 гаруй төлөөлөгч оролцлоо. Чуулганаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны төлөвлөгөөг гаргав.

Эрүүл мэндийн салбарт

Эрүүл мэндийн сайд клиникийн төв эмнэлэг, үндэсний төвүүд, нийслэлийн болон Дархан-Уул аймгийн эмнэлгүүдээр орж ажил байдалтай нь танилцан 1500 гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудтай уулзалт хийж, байгууллага, иргэдийн төлөөлөл 300 гаруй хүнийг хүлээн авч уулзав.

Салбарын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэхэд анхаарч байна. 2020 он хүртэл эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төлөвлөгөөтэйгөөр бэлтгэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2009-2020 он хүртэл хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийг бүх шатны эмнэлгийн байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлж үүнтэй холбогдуулан 2020 он хүртэлх салбарын хүний нөөцийн хэрэгцээний судалгааг Монгол Улсын хүн амын тоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал, төрлөөр ангилан тооцож гаргав.

Нарийн мэргэжлийн эмч нарын тусламжийг орон нутагт хүргэх, орон нутагт ажиллаж байгаа эмч нарын мэргэжил, ур чадварыг ажлын байранд нь дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг зохицуулах салбар зөвлөлийн 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Эмнэлгийн ажилтны урамшуулах багц”-ыг хэрэгжүүлж Улаанбаатар хот дахь төрөлжсөн мэргэжлийн төвүүдэд ажиллаж байсан 8 их эмчийг Баянхонгор, Ховд, Увс, Завхан, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь аймагт 6 сарын хугацаатай гэрээгээр ажиллуулж эхлэв.

Урамшууллын багцын нэг хэлбэр болох хөдөөд тогтвор суурьшилтай олон жил ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтныг дэмжих зорилгоор 21 аймгийн сувилахуйн албаны дарга нарыг АХБ-ны дэмжлэгтэйгээр англи хэлний 1 сарын сургалтад хамруулж, 10-аас дээш жил хөдөө суманд ажилласан 21 их эмчийг гадаадад танилцах аялалд хамруулж, сум, сум дундын эмнэлэгт 5-аас дээш жил ажилласан 64 эмчийг төрийн сангийн зардлаар хүссэн мэргэжлээр нь мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтад хамруулав.

Орон нутгийн удирдах ажилтнуудын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудлаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх нь” бүсчилсэн сургалтыг Сүхбаатар, Дархан-Уул, Ховд, Архангай аймагт зохион байгуулав.

“Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх нь” бүсчилсэн сургалт-семинарыг Увс, Өвөрхангай, Сүхбаатар, Дархан-Уул аймагт зохион байгуулав. Семинарт аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ЭМГ-ын дарга, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч, эрүүл мэндийн сургалт сурталчилгааны арга зүйч, халдвар судлагч, сум, өрхийн эмч зэрэг 210 гаруй хүн оролцож, нийгмийн эрүүл мэндийн бодлого, арга хэмжээний уялдаа холбоог хангах асуудлыг хэлэлцэв.

Аймаг, нийслэлийн хүүхдийн эмнэлгийн эрчимт эмчилгээ, хүлээн авах тасгийн эмч нарын дунд “Хүүхдэд эрэмбэлэн ангилах яаралтай тусламж үзүүлэх” стандарт сургалт зохион байгуулж, бэлтгэгдсэн сургагч багш нар Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЭНЭШТ-ийн эмч нарт үргэлжлүүлэн сургалт явуулж байна.

“Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын талаарх мэдлэг олгох зорилгоор “Сургагч багш бэлтгэх” сургалтыг Ховд, Орхон, Дорнод, Өвөрхангай аймгийн бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдэд зохион байгуулав.

Гэмтэл согог судлалын үндэсний төв, Шастины клиникийн төв эмнэлгийн хооронд телеконференц зохион байгуулж, өвчтөний зурган мэдээллийг дамжууллаа. Ингэснээр үйлчлүүлэгчдэд эмчилгээ, үйлчилгээг түргэн шуурхай, цаг алдалгүй үзүүлэх боломж нээгдэж байна.

Өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг өргөжүүлэх зорилгоор үндэсний төвүүдэд “Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн төв”-үүдийг нээж, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

Томуугийн цартахлын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд “Томуугийн үндэсний IY зөвлөлгөөн”-ийг зохион байгуулж, томуугийн цартахлаас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг үнэлж, зөвлөмж гаргав.

“Бид манлайлъя-Түншлэлийг хөгжүүлъя” уриан дор ХДХВ/ДОХ-ын Үндэсний 4 дүгээр чуулганыг зохион байгуулан төрийн ба төрийн бус байгууллагын 120 гаруй төлөөлөгчид оролцон ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх 2009-2015 оны үндэсний стратегийн төслийг хэлэлцэн хамтарсан уриалга гаргав.

Стандарт, нормыг шинэчлэн батлав. Хот суурин газрын агаарын бохирдлыг хянах тогтцолцоог бэхжүүлэх, шинжилгээний арга, технологийг олон улсын түвшинд хүргэх зорилгоор “Хүрээлэн буй орчны агаар, азотын давхар ислийг массын концентрацаар тодорхойлох химийн гэрэлтүүлгийн арга, ISO 7996 :1985” болон “Орчны агаар, угаарын хий тодорхойлох

сарнилтын бус хэт улаан туяат спектрометрийн арга , ISO 4224 :2000” олон улсын стандартуудыг үндэсний стандарт болгон батлав.

“Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2004 стандартад өөрчлөлт оруулж, батлав. Ингэснээр энгийн эмийн жорын маягтын цаасны хэмжээг шинэчилж, сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилтийн талаарх заалтыг нэмсний дээр эмийн жорын маягт дээрх зарим мэдээлэл зэрэг стандартын норматив шаардлагад хэд хэдэн өөрчлөлт оров.

Монгол хүний хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, эслэг, аминдэм, эрдэс бодис, хүнсний бүтээгдхүүний хоногийн хэрэгцээний жишиг хэмжээ, орлуулан хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн зэргийн хэмжээг тогтоож, хүн амд эрүүл амьдралын хэв маяг төлөвшүүлэх, хоол тэжээлийн дутлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор монгол хүний “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”-ыг шинэчлэн баталж, мөрдүүлж байна.

Материаллаг баазыг бэхжүүлж байна. БНСУ-ын сайн дурын сангийн хөрөнгө оруулалтаар Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд уруул, тагнайн төрөлхийн гажигтай хүүхдэд мэс засал хийх кабинет байгуулахаар боллоо.

Аймаг, дүүргийн эмнэлгүүдэд Япон улсын орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 2009 оноос эхлэн нийлүүлэх талаар “Асашёорюү сан”-тай гэрээ байгуулав. Хүн амд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийв. Үнэлгээнд гадаадын хөрөнгө оруулалттай, улсын болон орон нутгийн хэмжээний үйлчилгээтэй 773 хувийн хэвшлийн эмнэлэг, 193 эмийн сан хамрагдав.

Хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг аюулгүй, чанартай тээвэрлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар Халдварт өвчин судлалын үндэсний төвд анх удаа вакцин биобэлдмэлийг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж бүхий 25,000 ам.долларын үнэтэй автомашиныг хүлээн авснаар вакцин, биобэлдмэлийн чанарыг алдагдуулахгүйгээр нийслэл, зарим аймгуудад хүргэх боломжтой боллоо.

АНУ, Япон, БНСУ, Франц, Дани, ОХУ зэрэг орны эмийн болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн компанийн төлөөлөгчидтэй уулзаж Монгол Улсад хамтарсан эм, вакцины үйлдвэр байгуулах, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх асуудлаар санал солилцов.

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөрийн 4-р төслийн хүрээнд нийслэлийн эрүүл мэндийн салбарын тогтолцоог боловсронгуй болгож, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, Дэлхийн банк, Норвегийн сангийн хөрөнгөөр зайны оношлогооны сүлжээ байгуулах асуудлаар хэлэлцээр хийж эхлэв.

Хөдөө орон нутагт гэмтлийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар бүх аймгийн нэгдсэн эмнэлэгт тус бүр 10 гаруй сая төгрөгийн үнэ бүхий гэмтлийн мэс заслын багаж, хэрэгслийг олгож, улмаар аймгуудын нэгдсэн эмнэлгүүдэд гэмтлийн мэс заслын бие даасан кабинет байгуулах үүрэг өгч, 21 эмчийг нарийн мэргэжил олгох 6 сарын сургалтад хамруулав.

Эрүүл мэндийн салбарын хөгжил-2 хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын тушаалаар Өвөрхангай, Баянхонгор, Завхан зэрэг аймгуудад 1.0 тэрбум гаруй төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэв.

Алслагдсан аймгийн малчдад үзүүлэх эмнэлгийн хяналт, түргэн тусламжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын өвчлөлийг эрт үед нь оношлож, эмчлэх зорилгоор НҮБ-ын Хүн амын сангийн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн төсөл хэрэгжиж байгаа Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар болон Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Говь-Алтай аймгийн Бигэр, Увс аймгийн Малчин сумдад 218,9 сая төгрөгийн өртөг бүхий 15 автомашиныг нөхөн үржихүйн 5 нэр төрлийн тусламж үйлчилгээний багаж, хэрэгслийн хамт олгов.

Эрүүл мэндийн яам болон харъяа эрүүл мэндийн 15 байгууллагыг нэгдсэн сүлжээгээр холбох шилэн кабелийн холболт хийгдэж, цахим эмнэлгийн программ хангамжийг нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан эмнэлэг дундын нэгдсэн сүлжээг хүлээн авах арга хэмжээг зохион байгуулав.

Хөтөлбөрийн үнэлгээ. “Эрүүл мэндийн технологийг сайжруулах” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээг хийж, уг хөтөлбөрийг дуусгавар болгон, цаашид эрүүл мэндийн технологийн бодлогыг тодорхойлсон дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахаар шийдвэрлэв. Мөн “Сумын эмнэлгийн хөгжил” үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээг хийж, уг хөтөлбөрийг дуусгавар болгон, цаашид сумын эмнэлгийг хөгжүүлэх арга хэмжээг Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэхээр болов.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлж, тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх зорилгоор Нөхөн үржихүйн эм, хэрэгслийн тогтвортой хангамжийн стратегийн төслийг НҮБ-ын Хүн амын сантай хамтран боловсруулж, Монгол Улсын нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах асуудлаархи дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулав. Энэхүү стратегийг батлан хэрэгжүүлснээр Засгийн газрын санхүүжилтээр эмзэг бүлгийнхэн болон малчдыг жирэмслэлтээс хамгаалах хэрэгслээр найдвартай, тогтвортой хангах боломж бүрдэх юм.

Дархлаажуулалтын хөтөлбөрийн хүрээнд “Менингококкт халдвараас сэргийлье” уриан дор өвчлөл өндөртэй аймаг, нийслэлийн 2-10 насны 185336 хүүхдийг менингококкийн эсрэг вакцинаар дархлаажуулав. Үүний үр дүнд дахин шинээр өвчлөл бүртгэгдээгүй байна.

Нийтийн биеийн тамир. “Биеийн тамир, спортын шинэчлэл” сэдэвт үндэсний зөвлөлгөөнийг зохион байгуулж, нийтийн биеийн тамир, спортын хөгжлийг эрчимжүүлж, үр дүнг дээшлүүлэх асуудлаар зөвлөмж гаргав. “Биеийн тамир, спортын шинэчлэл” сэдэвт үндэсний зөвлөлгөөнөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”, “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

“Олимпын аваргууд - Эрүүл мэндийн төлөө хамтдаа” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, олимпын аварга, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавъяат тамирчин Э.Бадар-Ууганыг “Сүрьеэтэй тэмцэгч элч”-ээр өргөмжилж, тамирчид сүрьеэ өвчинтэй тэмцэх эрүүл мэндийн үйлсэд хамтран ажиллахаар болов.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт

Боловсрол. Зургаан настай сурагчдыг сургах, төлөвшүүлэх, сургуулийн орчинд дасгах талаар хүчин чармайлт гарган ажилласны үр дүнд дэлхийн жишигт нийцсэн ерөнхий боловсролын шинэ тогтолцооны

гарааг эхлүүлж чадлаа. Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлж эхэлсэнтэй холбогдуулан улсын төсөв, “Дэлхийн зөн” байгууллагын санхүүжилтээр 6 настай нэгдүгээр ангийн 501 бүлэгт сурагч, багшийн ширээ, сандал, самбарыг нийлүүлэв. Мөн хөдөө, орон нутгийн 21 сургуулийн дотуур байранд зөөлөн эдлэл, тавилга хэрэгсэл зэрэг нийт 550,0 мянган ам.долларын, бүх нэгдүгээр ангид 30 төрлийн 1,4 сая ам.долларын сургалтын хэрэглэгдэхүүн олголоо. Ингэснээр ерөнхий боловсролын сургуулийн 6 настай нэгдүгээр ангийн сурагчдын суралцах, амьдрах ая тухтай орчныг бүрдүүллээ.

Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, бага анги /6 настай хүүхдийн/-ийн багш нарыг 2 дахь удаагаа хамруулсан шинэ арга зүйн сургалтыг 21 аймаг, нийслэлд зохион байгуулав. Энэ нь 6 настай хүүхдийн ангийн сургалтын агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт зөвлөгөө өгөх, тэдний ур чадварыг дээшлүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Багшийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”, “Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”, “Багшлах эрх олгох, хасах журам”-ыг тус тус баталлаа.

Эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд сургуулийн номын сангаар дамжуулан 365.427.400 төгрөгийн сурах бичгийг олгосны гадна 10 нэрийн сурах бичгийг шинээр болон шинэчлэн хэвлэж сургалтад ашиглаж байна. Түүнчлэн казак хэл дээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн “Эх хэл” сурах бичгийг шинээр зохиож, “Математик”, “Бэлтгэл хөтөлбөр”, “Дүрслэх урлаг, технологи”, “Хөгжим”, “Хүн орчин” хичээлийн дасгал ажлын ном, сурах бичгийг монгол хэлнээс казак хэл рүү орчуулан хэвлэж, уг хэл дээр сургалт явагддаг бүх сургуулиудад хүргэлээ.

Сургуулийн орчин дахь хүчирхийллийн аливаа хэлбэрийг арилгах, сургуулийн үйл ажиллагаан дахь сурагчийн оролцоог өргөжүүлэх зорилгоор “Хүүхдэд ээлтэй сургуулийн хөгжилд сурагчдын оролцоо” Үндэсний чуулганыг зохион байгуулсны гадна энэ чиглэлээр жижиг төслийн тэтгэлэгт уралдааныг зарлаж, 50 төслийг шалгаруулж, батламж, 50000 төгрөгийн төслийн санхүүжилтийг олголоо.

“Хүүхдэд ээлтэй сургуулийн хөгжилд сэтгүүлчдийн оролцоо” сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн 25 сэтгүүлч оролцсон нь орон нутагт боловсролын үйлчилгээ, ялангуяа хүүхдэд ээлтэй сургуулийг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлыг олон нийтэд сурталчилсан чухал арга хэмжээ боллоо.

Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулах чиглэлээр тус хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй нийслэлийн 58 дугаар сургууль, хангалтгүй байгаа зарим сургуулиудын талаарх нэвтрүүлгийг МҮОНТ-тэй хамтран бэлтгэж, орон даяар нэвтрүүлсэн нь туршлагыг сурталчлахын зэрэгцээ бусдад сэрэмжлүүлэг, анхааруулга өгсөн, тухайн байгууллагыг үйл ажиллагаагаа сайжруулахад үр нөлөөгөө өгсөн ажил боллоо.

Багш, эцэг эхчүүд, сурагчдын танин мэдэхүйн хүрээг тэлэхэд чиглэсэн төрөл бүрийн сургалт, нэвтрүүлгийг бэлтгэн “Боловсрол” суваг телевизээр тогтмол явууллаа. Тус телевизээр нийт 50 гаруй нэвтрүүлгийг бүх аймаг, сум суурингийн хүн амд хүргэж, зайн сургалтаар мэдлэг боловсрол, ур чадвараа дээшлүүлэх боломжийг иргэдэд олголоо.

Ерөнхий боловсролын сургуулийг интернетэд холбох төслийн хүрээнд хот, хөдөөгийн 162 сургуульд интернэтийн урсгал орууллаа. Энэ ажлын үргэлжлэл болгож ерөнхий боловсролын сургуулийн 220 хичээлийн байр, аймгийн Боловсрол, соёлын газар, нийслэл, дүүргүүдийн Боловсролын хэлтсүүдийн 28 байрыг шилэн кабель болон сансарын хиймэл дагуулын VSAT систем ашиглан интернэтийн сүлжээнд холбох ажлыг хийж байна. Уг ажлыг хэрэгжүүлснээр ерөнхий боловсролын нийт сургуулийн 51,1 хувь нь интернэтийн сүлжээгээр дамжуулан хүссэн мэдээллээ авах нөхцөл бүрдэх юм. Англи хэлний онлайн олимпиадыг 21 аймаг, нийслэлд нэгэн зэрэг явууллаа.

Мэргэжлийн боловсролын салбарыг тусгайлан дэмжиж, энэ талаар хийгдэх ажлуудыг цогцоор нь шийдэх зорилгоор мэргэжлийн сургалт, техникийн боловсролд хувийн хэвшлийн оролцоог дэмжих, сургуулийг ажил олгогчтой шууд холбох, салбар хоорондын зохицуулалтыг оновчтой болгох зэрэг тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхэллээ.

Баянхонгор, Дорноговь, Дорнод, Завхан, Ховд, Хөвсгөл гэсэн бүсийн төвийн Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг загвар төв болгохоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-3” төслийн хүрээнд техникийн болон суурь мэргэжлийн лаборатори, цахилгаан, хөдөө аж ахуй-газар тариалан усжуулалт, авто механик, барилга, хоол-хүнс үйлдвэрлэл гэсэн 6 мэргэжлийн чиглэлээр 1,8 сая ам.долларын өртөг бүхий сургалтын болон дадлагын тоног төхөөрөмж нийлүүлэхээр шийдвэрлэв. Уг сургалтын багаж, хэрэгслийн жагсаалтыг мэргэжил тус бүрээр гаргаж, олон улсын тендерийг зарлаад байна. Энэ ажлыг хэрэгжүүлснээр орчин үеийн тоног төхөөрөмж бүхий сургалтын шаардлага хангасан мэргэжлийн сургуулийн бааз суурь бий болох юм.

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанарт үнэлгээ өгөх, тэдэнд тавих шаардлагыг өндөржүүлэх замаар чанарын шаардлага хангасан сургуулийг тусгайлан дэмжиж ажиллах бодлого баримталж, энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулан дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дүгнэлт хийхэд баримтлах шалгуур үзүүлэлтийг боловсрууллаа.

Их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн болон их сургуулийн хотхоны үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтад модулийн сургалтыг нэвтрүүлэх, модулийн санг өргөтгөх үүднээс 30 мэргэжлийн хүрээнд 94 модульчилсан хөтөлбөрт хамаарах 1000 орчим модулийг дахин кодлож шинэ формат руу шилжүүлж, 34 модульчилсан хөтөлбөр бүхий нийт 452 модулийг шинээр боловсрууллаа. Модулийн сангийн програм хангамжийг шинэчлэх, хэрэглэхэд хялбар болгох зорилгоор <http://www.nmc.mn/> санг ажиллуулж байна.

Боловсролын тухай хуулийн дагуу их, дээд сургууль, коллежийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг боловсролын стандарт, норм нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор аттестатчилах үйл ажиллагааг явуулж байна. Одоогоор 25 сургуульд аттестатчилал явуулж, 7 байгууллагад хугацаатай үүрэг өгөв. Энэхүү үйл ажиллагаа нь сургуулиуд сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, номын сангийн фондыг баяжуулах, багшлах боловсон хүчний хангамж, суралцагчдад олгож буй мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна. Оюутан, сурагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлж, олон нийтэд энэхүү үйл ажиллагааг сурталчлах хэвлэлийн бага хурал зохион байгууллаа.

“Хүний эрх-Хүүхдийн эрхээс эхэлнэ” 16 хоногийн аяныг НҮБ-ын Хүн Амын сан, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Хүүхдийн төлөө Үндэсний газартай хамтран 2008 оны 11 дүгээр сарын 25-аас эхлэн ерөнхий боловсролын сургууль бүр дээр зохион байгуулахаар шийдвэрлэж, аяны удирдамж, арга зүйн гарын авлагыг боловсруулан орон нутагт хүргүүллээ. Энэ аяны хүрээнд сурагчдад зориулсан сургалт, уулзалт, ярилцлага, мэдээллийн самбар ажиллуулах, хүүхдийг аливаа хүчирхийллээс хамгаалахад нийгмийн ажилтан, багш, эцэг эх, үе тэнгийнхний оролцоог нэмэгдүүлэх олон талын үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд үр дүнг 2008 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дүгнэнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж буй аливаа уралдаан тэмцээн, олимпиадад оролцох болон хичээлийн бус цагаар биеийн тамирын заал ашигласны төлөө сурагчдаас төлбөр, хураамж авахгүй байх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал гарган хэрэгжүүлж эхэллээ.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжих бага, дунд сургуулийн шинэ барилга, өргөтгөлийн 4 дүгээр шатны төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төслийн баримт бичигт хоёр тал гарын үсэг зурлаа. Үүний дүнд 2009-2010 онд Улаанбаатар хотод 5 сургуулийг шинээр барьж, 7 сургуулийг өргөтгөх бөгөөд ингэснээр Улаанбаатарт ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжийг арилгах боломжтой болох юм.

Сургууль, цэцэрлэг, соёлын төв, спорт заалны 15 шинэ барилгыг ашиглалтад хүлээн авч, боловсрол, соёл, шинжлэх ухааны 250 гаруй байгууллагад сурагч, багшийн ширээ сандал, тавилга, тоног төхөөрөмж, 131 соёлын төвд хөгжмийн зэмсэг шинээр нийлүүлснээр сургуулийн суудлын тоо 2120-оор, цэцэрлэгийн орны тоо 300-аар нэмэгдэж, боловсрол, соёлын байгууллагын үйлчилгээний таатай орчин өргөжлөө.

Азийн Хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар 2009-2013 онд хэрэгжих Боловсролын шинэтгэлийн төслийн хэлэлцээрийг хийж, АХБ-аас 10,0 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгохоор боллоо.

Соёл, урлаг. Улс, аймгийн музейн тооллогыг явуулж, улсын 8, орон нутгийн 24 музейгээс гадна Үндэсний номын сан, Археологийн хүрээлэн, Палентологийн төв зэрэг нийт 35 байгууллагыг хамрууллаа. Тооллогыг анх удаа зохион байгуулж байгаа бөгөөд үр дүнд нь улсын хэмжээний үзмэрийн нэгдсэн бүртгэл мэдээлэлтэй боллоо. Нийт тоологдсон 206109 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийн 103637 нь улсын музейд, 102472 нь аймаг, байгууллагын музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Тооллогын дүнд үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөж байна.

Ардын уран зохиолч, эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэж, энэ хүрээнд “Ц.Дамдинсүрэнгийн эрдэм шинжилгээний бүтээл”, “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар” 4 цуврал номыг хэвлүүлэх, их зохиолчийн гэр музейг сэргээн засварлах ажлууд хийгдлээ.

“Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал”-ын хөгжимчдийн 60,6 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн хувцас, хэрэглэлийг бэлтгэн хүлээлгэн өгөв. “Монгол төрийн үндэсний хөгжмийн их найрал”-д 168,7 сая төгрөгийн 4 төрлийн 35 нэрийн 128 ширхэг үндэсний хөгжмийг нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

“Хүүхэд багачуудын оюуны эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц хүүхдийн уран сэтгэмж, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн “Шилдэг уран бүтээлийн улсын 2 дугаар уралдаан”-ыг зарлаад байна. Уралдааныг

бага, дунд ангийн хүүхдэд зориулсан драмын жүжиг, ахлах ангийн хүүхдүүдэд зориулсан драмын жүжиг, хүүхдэд зориулсан мюзикл, хүүхэлдэйн жүжиг, хүүхдэд зориулсан уран сайхны кино, хүүхэлдэйн кино зэрэг төрлүүдээр явуулахаас гадна энэ үеэр хүүхдэд зориулсан шинэ дуу шүлгийн уралдаан явагдана. “Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний хүрээг өргөтгөж, шинэ, шилдэг 51 бүтээлийг шалгаруулан үзэгч олны хүртээл болголоо.

Азийн сантай хамтран нийт 347 сум, аймгийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимд тус бүр 200 нэрийн нийт 69200 ширхэг хүүхдэд зориулсан ном, хэвлэл, англи хэлний анхан болон дунд шатны сурах бичиг, гарын авлагыг нийлүүлэв.

“Дунд боловсролын түвшинд унших уран зохиол”-ын 5 цуврал бүхий 2500 номыг нийт сум, сургуулийн номын санд хүргэхэд бэлэн болоод байна.

Шинжлэх ухаан, технологи. Шинжлэх ухаан, технологийн салбарт биотехнологи, нанотехнологийн чиглэлээр 2008, 2009 оноос хэрэгжүүлж эхлэх нийт 17634,2 сая төгрөгийн өртөг бүхий 61 төслийн ажлыг шалгаруулах ажлыг эхлээд байна.

“Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, шинжлэх ухааны ололтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн-2008” үзэсгэлэнг амжилттай зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний 30 гаруй байгууллага, МУИС, ШУТИС-ийн салбар сургуулиуд сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн судалгааны ажлын үр дүнгээ нано, био, мэдээллийн технологи, инновацийн бүтээгдэхүүн гэсэн 4 хэсэгт дэлгэн үзүүлж, олон нийтэд сурталчиллаа.

Төрийн захиргааны болон эрдэм шинжилгээний хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон “Судалгаа боловсруулалтын ажлын үр ашгийг нэмэгдүүлэхэд хувийн секторын оролцоо” сэдэвт уулзалтыг 2008 оны 11 дүгээр сард зохион байгуулсан нь энэ салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чухал ажил боллоо.

Санхүү, эдийн засгийн салбарт

Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг батлав. Олон улсын зах зээлийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг эрсдэл багатай даван туулах чиглэлээр Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг УИХ-аар батлуулав. Энэ хуулийн зорилт нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуулиар банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс гаргах баталгаа нь мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид хамаарах бөгөөд энэхүү баталгаа нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд хүчинтэй байж, баталгааны хугацаанд арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид учирсан хохирлыг төр бүрэн хариуцахаар хуульчлав.

Төсвийн тодотгол. Олон улсын санхүүгийн зах зээлд үүссэн нөхцөл байдал, түүхий эдийн үнийн уналттай уялдуулан 2008 онд төлөвлөсөн нийгмийн арга хэмжээг бууруулахгүйгээр Засгийн газрын зарим зарлагыг хязгаарлах замаар Монгол Улсын 2008 оны төсвийн тодотголыг богино хугацаанд амжилттай батлуулж чадлаа. Монгол Улсын 2008 оны

төсвийн тодотголыг боловсруулах явцад төсвийн урсгал зарлагыг хязгаарлах, цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зарлагыг өсгөхгүй байх; төрийн албаны орон тоо, зардлыг нэмэгдүүлэхгүй байх, нэн чухал бус хөрөнгө оруулалтыг тэвчих замаар чөлөөлөгдсөн хөрөнгийн эх үүсвэрийг тогтмол зардлын үнийн өсөлт болон зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээг санхүүжүүлэх, зураг төсөл нь бэлэн болоогүй, тендер зарлагдаагүй бөгөөд 2008 онд эхлүүлэх боломжгүй барилга байгууламжийг дараа жилийн төсөвт шилжүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлтэй уялдуулан 2008 онд ашиглалтад орох боломжтой барилгад хүч хөрөнгийг төвлөрүүлэх; улмаар төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлийг баримталж ажиллалаа.

Монгол Улсын төсвийн 2008 оны алдагдлыг 228.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 4.2 хувь байсныг төсвийн тодотголоор алдагдлыг 95.3 тэрбум төгрөг болгож, түүний ДНБ-д эзлэх хувийн жинг 1.6 хувь байхаар тогтоож, алдагдлын хэмжээг даруй 2.5 нэгжээр багасгахаар тооцсон болно.

Үндсэн чиглэл. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг УИХ-аар батлуулав. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нягт уялдуулан батлуулсан явдал гарааны эхлэлийг тавьсан бодлогын томоохон баримт бичиг боллоо. Тус үндсэн чиглэлд Макро эдийн засгийн бодлого, Бодит салбарын хөгжлийн бодлого, Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого, Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлого, Гадаад бодлого, батлан хамгаалах, засаглал, эрхзүйн шинэчлэл гэсэн 6 чиглэлээр нийтдээ 21 зорилт, 248 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа. 2009 онд ДНБ-ий өсөлтийг 10.1 хувь, бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг 9.0 хувь байлгахаар тооцож, ДНБ-ий нийт хэмжээг (оны үнээр) 6482.0 тэрбум төгрөгт буюу нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 2042.1 ам.долларт хүргэх зорилт тавьж байна. Түүнчлэн эдийн засгийн өсөлтийг хадгалах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нийгмийн салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээг үргэлжлүүлэх, хүн амын бодит орлогыг өсгөх, шинээр ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, улмаар хүнсний хангамжийг сайжруулан мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх гол зорилтыг дэвшүүлж байна.

Монгол Улсын 2009 оны төсөв. Манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ буурсан хэдий ч 2009 он Монгол Улсын түүхэнд хамгийн их хэмжээний төсвийг батлуулсан жил боллоо. Монгол Улсын 2009 оны төсвийг шахуу хугацаанд УИХ-аар дөрвөн удаа хэлэлцүүлж, улмаар УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2009 оны төсвийн тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуулийг батлууллаа. Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн нийт орлогын доод хэмжээг 2,223.8 тэрбум төгрөгөөр, улсын төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 2,619.5 тэрбум төгрөгөөр баталж, нэгдсэн төсвийн урсгал тэнцлийн ашиг 298.8 тэрбум төгрөг, нийт тэнцлийн алдагдал 395.7 тэрбум төгрөг байхаар тогтоож, арга буюу төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн жинг 6.1 хувьтай байлгахаар тооцлоо. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн орлогыг 45.2 тэрбум төгрөг, зарлагыг 115.3 тэрбум төгрөгөөр баталж, сангийн алдагдлыг 70.1 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Нийгмийн

даатгалын сангийн 2009 оны төсвийн орлогыг 463.9 тэрбум төгрөгөөр, зарлагыг 433.9 тэрбум төгрөгөөр баталж, сангийн хөрөнгийн ашгийг 29.9 тэрбум төгрөг байхаар тогтоосон байна.

Монгол Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх чиглэлээр зарим хууль тогтоомжид нэмэлт оруулах ажлыг зохион байгууллаа. Тухайлбал, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын (2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн) нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, алтны босго үнэ 500 ам.доллар байсныг 850.0 ам доллар болгож нэмэгдүүлсэн байна. Үүний дүнд алт олборлогч аж ахуйн нэгжийн төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 4.3-8.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэх юм.

Түүнчлэн “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” (2008 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 8 дугаар) тогтоол гаргаж импортын автобензин, дизелийн түлшинд ногдох албан татварыг сэргээх арга хэмжээ авлаа. Энэхүү тогтоолоор 2008 оны аравдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний гаалийн албан татварыг “5” хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварыг “10” хувиар, улмаар автобензин, дизелийн түлшийг импортоор байгаа боомтоос нь хамааруулан ногдуулах онцгой албан татварын хэмжээг ялгаатай тогтоож мөрдүүлэхээр заасан юм.

Бусад асуудал. Засгийн газрын санхүүгийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хүч чадлыг ашиглан санхүү, төсөв, зээл, тусламж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах нөхцөл, боломж нэмэгдэж байна. Төсвийн ил тод байдал (www.iltod.gov.mn), Засгийн газрын худалдан авах ажиллагаа (www.e-procurement.mn), Гадаадын зээл, тусламж (www.ams.gov.mn) цахим хуудсыг шинэчлэх ажлыг зохион байгуулан ашиглаж эхлээд байна. Эдгээр цахим хуудсыг шинэчлэн багтаамжийг өргөжүүлснээр төсвийн болон худалдан авах ажиллагаа, гадаадын зээл, тусламжийн холбогдолтой мэдээ, мэдээлэл болон зарим гарын авлага, гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомж, дүрэм, журмыг олон нийтэд тогтмол мэдээлэх боломж бүрдэж байна.

Гаалийн орлого бүрдүүлэлтийн ил тод байдлыг хангах үүднээс улс орон даяар “ӨНДӨР ГОНГОР” аяныг өрнүүлж, аяны хүрээнд илрүүлсэн зөрчил, барагдуулсан татвар, хураамжийн тайлан мэдээг тухай бүр цахим сүлжээгээр дамжуулан Гаалийн дотоод мэдээллийн (E-documents) программ хангамжийн файлын санд байрлуулан мэдээлж байна. Аяны явцад гаалийн 68 улсын байцаагч худалдааны луйвартай холбоо бүхий 90 гаруй зөрчил илрүүлэн 13.3 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 7.5 сая төгрөгийн торгууль, улмаар захиргааны зөрчилтэй холбоотой 667 зөрчил илрүүлж 280.5 сая төгрөгийн татвар, 60.9 сая төгрөгийн торгууль нийт 362.2 сая төгрөгийн татвар, торгуулийг нөхөн ногдуулж барагдуулсан байна.

Үндэсний татварын ерөнхий газрын бүтцэд Утсаар зөвлөгөө өгөх төвийг нээж ажиллуулснаар зуун хоногийн хугацаанд 3863 иргэн, татвар төлөгч болон 191235 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (давхардсан тоогоор) Татварын албаны цахим хуудсанд хандаж зөвлөгөө авсан байна. Орон нутгийн татвар төлөгчдөөс цахим тайлан хүлээн авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, татварын албадын сүлжээний бүтцэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн эхний ээлжинд Дархан-Уул, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Баянхонгор аймгийн болон

Багануур, Налайх дүүргийн татварын албыг шилэн кабелийн сүлжээнд холбох арга хэмжээ авлаа. Улсын хэмжээнд 2008 оны 10 дугаар сарын байдлаар НӨАТ-ын тайлангийн 79.9 хувийг, НӨАТ-ын падааны 51.0 хувийг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн 60.4 хувийг, хүн амын орлогын албан татварын тайлангийн 66.9 хувийг цахим хэлбэрээр тушаасан байна.

Засгийн газар Дэлхийн банкттай хамтран “Эдийн засгийн бодлогын чуулга уулзалт”-ыг Улаанбаатар хотноо (2008 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд) зохион байгуулав. Энэ үеэр Монгол Улс нөөц баялгаа хэрхэн зөв ашиглан хөгжиж болох талаар олон улсын байгууллагатай нээлттэй санал солилцсон төдийгүй Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл, түүний тэргүүлэх чиглэлийн талаар гадаадын ажиглагчдын үзэл бодлыг сонсож, тэдний саналыг хөтөлбөрт тусгах чиглэлээр ярилцлага өрнүүлсэн байна. Чуулга уулзалтад олон улсын байгууллага, төр засгийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэд, оюутны төлөөлөл нийт 800 гаруй хүн оролцож, санал бодлоо илэрхийллээ.

БНХАУ-ын 300,0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Баруун бүсийн авто зам”, “Орон сууцны хороолол (инженерийн дэд бүтэц, барилгын материал)”, “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх”, “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах”, “Мэдээлэл, холбооны нэгдсэн сүлжээний шинэчлэл” төслийг тус тус санхүүжүүлэхээр шийдвэрлэв.

Малчид болон малтай иргэдэд ноолуурын үнийн уналттай холбогдуулан мөнгөн дэмжлэг үзүүлэхээр боллоо. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай хуулиар 2007 оны жилийн эцсийн мал тооллогын дүнг үндэслэн ямааны тоогоор тооцож нэг килограмм ноолуур тутамд 5000 төгрөгийг малчид болон малтай иргэдэд нэг удаа олгохоор боллоо. Энэ нэг удаагийн арга хэмжээнд шаардагдах 30.5 тэрбум төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхээр тогтов. Уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар Монгол Улсыг хөгжүүлэх сангаас мал тооллогын 2007 оны дүнг үндэслэн ямааны тоогоор тооцож, нэг килограмм ноолуур тутамд малчид болон малтай иргэнд нэг удаа олгох таван мянган төгрөгийн хөрөнгийн аймаг, нийслэл, сум, дүүргийн мөнгөн дүнгийн хуваарийг баталж, малчдад мөнгө олгох арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг холбогдох яам, байгууллага, орон нутгийн удирдлагад үүрэг болгон ажиллаж байна.

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт

Авто зам. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд авто замын талаар тусгагдсан авто замын сүлжээг өргөтгөн сайжруулах, “Мянганы зам” төслийг үргэлжлүүлж, тулгуур хотууд, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбож бүс нутгийн зам харилцааг сайжруулах, авто замын сүлжээг авто тээврийн хэрэгсэл зорчих байнгын бэлэн байдалд байлгах чиглэл баримтлан ажиллаж байна.

Авто зам, гүүрийн засварын ажилд 2009 онд 9.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж улсын чанартай 11218.9 км авто зам, 13523.4 у/м гүүрийг авто замын засвар, арчлалтын компаниудтай зам, гүүрийн байнгын засвар, арчлалтын гэрээ байгуулан гүйцэтгүүлэх бэлтгэлийг хангаж байна.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар улсын чанартай авто замын цасанд хаагддаг, хальтиргаа гулгаа үүсдэг зам даваануудад тээврийн хэрэгслийг саадгүй нэвтрүүлэх, байнгын бэлэн

байдалд байлгах шуурхай хэсгийг 2008 оны 11 дүгээр сараас 32 цэгт байгуулан ажиллаж байна.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудын засвар, арчлалтын ажлын гүйцэтгэл 2008 оны 11 дүгээр сарын 21-ний байдлаар 7 417.6 сая буюу 82.3 хувьтай байгаа бөгөөд улсын чанартай авто зам, гүүрэнд гарсан гэнэтийн эвдрэлийг засварлахад шаардагдах 359.0 сая төгрөгийг замын засвар, арчлалтын ажлын 2008 оны төлөвлөгөөнд зохицуулалт хийж шийдвэрлэв.

Авто зам, гүүрийн барилгын ажлын санхүүжилтэд Улсын төсвөөс 19.7229.0 сая төгрөг буюу /21.611.1 сая төгрөгөөр төлөвлөгдсөн/ санхүүжилтийн 91.3 хувийг, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 16,472.7 сая төгрөг буюу /40,302.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөн/ санхүүжилтийн 40.9 хувийг гүйцэтгэгч байгууллагуудад тус тус олгоод байна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн Бууралхангай, Дархан-Сүхбаатар чиглэлийн Дулаанхаан, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн Хартуулайт, Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн Онгийн гүүрийн төлбөр хураах цэгүүдийн байр, гадна замын тохижилт, гадна гэрэлтүүлэг, автомат хаалт, мөн "Орхон АЗЗА" ХК-ийн шинэ контор, гаражийн барилгыг ашиглалтад оруулав.

Сүхбаатар аймгийн Отгон сумын 9 у/м төмөрбетон гүүр, Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 10.4 км хайрган хучилттай авто зам, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам, Дорнод аймгийн Алтан голын 17.5 у/м төмөр бетон гүүрүүдийг ашиглалтад авлаа.

Мөн Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Багануур-Өндөрхааны чиглэлд баригдах 58.5 км замын эхний ээлж болох Мөрөн-Өндөрхаан чиглэлд баригдсан 28.2 км хатуу хучилттай замыг ашиглалтад хүлээн авч хөдөлгөөнийг нээлээ. Энэхүү төсөл хэрэгжиж дууссаны дараа уг зам барилгад ашигласан 71 машин механизм, тоног төхөөрөмжийг Монголын талд хүлээлгэн өгөх юм.

Авто тээвэр. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах 38.4 тэрбум төгрөгийг 2009 оны төсвийн төсөлд тусган санхүүжүүлэх, энэ зориулалтаар худалдан авах том оврын 400 автобусны урьдчилгаа 3.8 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэв. 400 автобус нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. Мөн замын цагдаагийн албаны хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын гудамж, замыг 24 цагийн байнгын хяналтад оруулах, нийтийн тээврийн хэрэгслийн болон таксийн зогсоол барих асуудлыг шийдвэрлэв.

Иргэний нисэх. Нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд нислэгийн ажиглалтын радиолокатор 3 ширхэг, навигацийн VOR/DME төхөөрөмж 4 ширхэг худалдан авч, суурилуулах ажлыг хийж байна.

Радиолокатор суурилуулах газруудын зам тавих, цахилгаан дамжуулах шугам татах барилгын ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай байна. Газрын навигацийн DVOR/DME систем 4 ширхэгийг Улаанбаатар, Сайншанд, Алтай, Мөрөн хотуудад суурилуулах ажил 90-95 хувьтай байна. DVOR/DME системүүд үйлдвэрлэгчээс ачигдаж, Замын-Үүд боомт дээр гаалийн бүрдүүлэлт хийгдэж байна.

Улаанбаатар хотод олон улсын шинэ нисэх буудал байгуулах төслийн эцсийн судалгааг Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банкнаас томилогдсон судалгааны баг гүйцэтгэж, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж дуусгалаа. Шинэ нисэх буудлыг байгуулах төслийн зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж ажилд нь оруулав. Шинэ нисэх

буудлыг ойролцоогоор 270.0 сая ам.долларын санхүүжилтээр 2015 он гэхэд барьж дуусгахаар төлөвлөсөн болно.

Төмөр зам. Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх, экспортын зах зээлийг өргөтгөхөд чухал нөлөө үзүүлэх ашигт малтмалын орд газруудыг шинээр эзэмших, ашиглахтай холбогдуулан төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдгээр ордуудыг холбосон төмөр замын шинэ сүлжээг байгуулах хөрөнгө оруулалт, өмчлөлийн эрх зүйн орчныг бий болгох, одоо байгаа төмөр замаар өмчийн бусад хэлбэрийн байгууллагууд төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд төмөр замын сүлжээг өргөтгөх хэтийн төлөвийн асуудлаар холбогдох зөвлөмж, саналын төслийг боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахад бэлэн болоод байна.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд ОХУ-д айлчилж Орос, Монголын зам, тээвэр, барилгын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, ялангуяа төмөр замын салбарын тулгамдсан асуудал, цаашдын хамтын ажиллагааны талаар холбогдох албаныхантай санал солилцлоо.

Үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх ажлын хүрээнд төмөр замын салбарт хамтран ажиллах Монгол-Оросын ажлын хэсгүүд байгуулагдаж, хамтарсан хуулийн этгээд байгуулах тухай Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, “Оросын төмөр зам” НХН-ийн хоорондын протоколд Улаанбаатар хотноо гарын үсэг зурлаа. Протоколын дагуу ажлын хэсгүүд хамтарсан байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлж, хуулийн этгээд байгуулах ажлыг дэс дараатай хийхээр тохиролцов.

Монгол Улс, БНХАУ хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулахад үүсч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах зорилгоор Замын-Үүд боомтод шилжүүлэн ачих 3 дахь терминалийг ашиглалтад оруулж, контейнер ачих хүнд даацын 2 кран шинээр авч хүчин чадлыг нь нэмэгдүүллээ.

Усан зам, далайн тээвэр. Усан замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд усан замын тээврийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, аюулгүй байдлын хангалтыг дээшлүүлэх чиглэлээр нилээд ажлууд хийгдэж байна.

Энэ ажлын хүрээнд усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээжүүлэн улсын дугаар олгож, техникийн болон экологийн хяналтын үзлэг хийлээ.

Хөвсгөл нуурын эрэгт усан замын зорчигч, ачаа тээврийн зогсоол, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын нутагт Орхон гол дээр /гатлага онгоц/ бяргаазыг барьж ашиглалтад хүлээн авав.

Цаашид Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг улам чанаржуулах, бүртгэлээс олох орлогын хэмжээг нэмэгдүүлэх, далайн тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дотоодын усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлд усан замын тээврийн хэрэгслүүдийг бүрэн хамруулж, техникийн болон экологийн аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулан хөрөнгө оруулалтыг татах, төсөл боловсруулах, үндэсний мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх зорилтыг тавьж байна.

Барилга, орон сууц, нийтийн аж ахуй. Засгийн газраас 2005 онд баталсан “40000 орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн шаардагдах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, орон сууцны үнийн зохиомол өсөлтөд хяналт тавих, орон сууцны барилгын чанарын хяналтыг сайжруулах, ахмад дайчдад зориулж хямд төсөр орон сууц барих ажлыг зохион байгуулж,

2009 оны хавраас ахмад дайчдад орон сууц олгохоор төлөвлөж байгаагийн дээр “100 000 орон сууц” хөтөлбөр боловсруулах ажлыг эхлээд байна.

2008 оны 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 4754 айлын 122 орон сууцны барилга ашиглалтад ороод байна. Орон сууцны санхүүжилтийн төсөлд оролцогч 5 арилжааны банкнаас 1,446,504,072 төгрөгийн хөрөнгийг Орон сууц хөгжүүлэх санд төвлөрүүллээ.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтны зөвлөлгөөнийг “Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах, өөрчлөн байгуулах чиглэлийг хэрэгжүүлэх нь” сэдвийн дор 2008 оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Дотоодын түүхий эдэд түшиглэн цемент, арматур, төмөр хийц, шил зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлнэ” гэж заасантай холбогдуулан дээрх материалуудын болон дулаан тусгаарлах материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, түүхий эдийн орд, нөөцийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, материалыг үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчид, төсөл хэрэгжүүлэгчдэд зориулан хийлээ. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Иргэдийн орон сууцны зээлийн хангамжийг сайжруулах, орон сууцны зориулалтаар барилгын компани, иргэдэд өмнө нь олгогдсон зээлийг төлөх бодит боломжийг судлан, цаашид авах арга хэмжээний нэгдсэн санал боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын удирдамжийг баталлаа.

Хот байгуулалт, газрын харилцаа, эрхийн бүртгэл. “Хархорин, Эрдэнэ зуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулах ажлын хүрээнд Хангайн бүс нутгийн аялал жуулчлалын гол газар нутаг болох Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өгий нуур сум, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий зэрэг сумдын нийт 13352 км² газар нутгийг хамарсан нарийвчилсан судалгаа хийж, байгаль-экологи, хот байгуулалт, аялал жуулчлал, түүх археологийн одоогийн байдлын талаар дүгнэлт гаргаж, дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагатай уялдуулах боломжийг судлав. Хөтөлбөрийн эхлэл болон явцын тайлан хийгдсэн бөгөөд одоо эцсийн тайланг нэгтгэж, улсын экспертиз хийлгэхээр холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Мөн Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан аймгуудыг хамарсан “Баруун бүсийн хөгжлийн төсөл”-д улсын экспертиз хийлгэж байна.

“Монгол Улсын бүлэг суурингийн тогтолцооны баримт бичиг”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын нутаг дэвсгэрт байрлах стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг түшиглэн бүс нутгийн түвшинд 2007-2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгааг орон нутгаар гаргуулсны үндсэн дээр бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж төслийн тайланг дуусгав.

Энэхүү төсөл нь говийн бүсийн хөгжлийн чиг хандлага; Тавантолгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн орд газруудыг түшиглэсэн Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Манлай, Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумуудын нутаг дэвсгэрийг хамарсан бүс нутгийн хөгжлийн стратеги болон тус бүс нутгийн хот байгуулалтын төлөвлөгөө гэсэн чиглэлээр хийгдсэн бөгөөд төслийн нэгдүгээр үе шат нь 2007-2015 он, хоёрдугаар үе шат нь 2016-2021 он байхаар төлөвлөсөн болно.

Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдах, 20.0-25.0 мянган оюутан, багш ажилчид амьдрах “Оюутны хотхон”-ы техник-эдийн засгийн үндэслэл, ерөнхий

төлөвлөгөө, эхний ээлжинд баригдах 12 давхар 3 байр, оюутны 9 давхар 3 байр, багш, ажилчдын сууц, үйлчилгээний төв, хашаа, хотхоны гол шугам сүлжээнүүд /дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуурга, холбоо/-ийн ажлын зураг төслийг боловсруулаад байна.

Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Кадастрын зураглал ба газрын бүртгэл” төслийн хүрээнд Зүүн болон говийн аймгуудын кадастрын зураг, бүртгэлийн ажлыг хийсэн компаниудын ажлуудыг хүлээн авлаа. Уг төслийн хүрээнд хийгдэх баруун аймгуудын төвийн агаарын зургийн ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарт

Монгол Улсын “Үндсэн сүлжээг өргөтгөх, интернэт протокол дээр суурилсан дамжуулах систем нэвтрүүлэх”, “Аймгуудын төв, сумдад түгээх сүлжээ зохион байгуулах” төслүүдийг англи, монгол хэл дээр боловсруулав. Энэхүү төсөл нь БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжих юм. Монгол Улсад ашиглаж байгаа аналог радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх бодлогын баримтлах чиглэлийг боловсруулж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах” багц төслүүдийн хүрээнд “Засгийн газрын болон иргэний портал систем, Засгийн газрын дотоод сүлжээг боловсруулах” төсөл, тендерийн бичиг баримтыг боловсруулах асуудлаар санамж бичигт гарын үсэг зурлаа.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан авилгыг бууруулах, түүнтэй хэрхэн тэмцэх талаар Авилгатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна.

“Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын вэб хуудасны чанар, агуулгыг сайжруулах зорилгоор шилдэг вэб хуудас шалгаруулах уралдаант шалгаруулалтын ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төрийн байгууллагуудын цахим хуудсанд хяналт шинжилгээ хийх, цаашид баримтлах стандарт загварыг бий болгох, алслагдсан сумдад шилэн кабелийн дамжуулах систем ашиглах асуудлаар харьцуулсан судалгаа хийж байна.

“Орон нутгийг мэдээлэлжүүлэх төсөл”-өөр орон нутагт суурилуулсан телевизийн нэвтрүүлгийн олон сувгийг хүлээн авч, дахин дамжуулах тоног төхөөрөмжийг улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн МХХТ-ийн төвийн санаачилгаар боловсруулсан “Засгийн газрын удирдах албан тушаалтнуудад зориулсан МХХТ-ийн сургалт”-ын хөтөлбөрийн нэг хэсэг болох “Хөгжлийн бодлогод МХХТ-ийн үүрэг” сэдэвт сургалтыг зохион байгуулав. “Чадамжтай багш-компьютер”, “Багш бүрт компьютер” төслийг тус тус боловсрууллаа.

“Мэдээлэл, холбооны технологийн шилдэг сонголт-2008” гурав дахь удаагийн шалгаруулалтыг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар, Мидас/Монитм төрийн бус байгууллага, Мэдээллийн технологийн үндэсний паркттай хамтран орон даяар зохион байгуулахаар бэлтгэж байна. Энэхүү шалгаруулалт нь мэдээлэл, холбооны технологийн ололт амжилтыг олон нийтэд хүргэх, хэрэглэгчдэд МХТ-ийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зөв сонголт хийхэд нь туслах, шилдэг бүтээгдэхүүн болон үйлчилгээг тодруулах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт

Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, Байгалийн ургамлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

“Ашигт малтмалын нөөцийг олборлох, баяжуулах явцад байгаль орчинд учрах хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээг тооцох аргачлал”-ыг батлан мөрдөж эхэллээ. “Агаар бохирдуулагч бодисын хүлхэц хэм хэмжээ”-ний болон уул уурхайн олборлолтод өртсөн газрыг нөхөн сэргээх ажлын багц стандартыг боловсруулж батлав.

Байгаль орчны хамгаалалт, иргэний нийгмийн байгууллагын оролцоо. Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор орон тооны бус зөвлөлийг байгуулан зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд 64 ажлыг тусган хэрэгжүүлж байна.

Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын улсын анхдугаар зөвлөгөөнийг 2008 оны 11 дүгээр сард зохион байгуулав. Зөвлөлгөөний үеэр төрийн бус байгууллагын зөвлөл байгуулж, хамтран ажиллах чиглэлүүдийг тогтож, хамтын ажиллагааны гэрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай гарын үсэг зурав. Гэрээний дагуу төрийн бус байгууллагын зөвлөлийг ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангаж, тэдний төлөөллийг сайдын зөвлөл, шийдвэр гаргах бүтцийн бүрэлдэхүүнд оролцуулах боломжийг бүрдүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлж болох 21 ажлын жагсаалтыг баталж мөрдөх болсноор төрийн болоод төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх нэг алхам болов.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Баянхонгор аймгийн Их Богд уулын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааг Баянхонгор аймгийн төвд байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэв. Завхан аймгийн Хүнгүйн хар нуур, Улаагчины хар нуур, Говь-Алтай, Завхан аймгийн зааг Монгол элсний орчмын газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар, Ховд, Увс аймгуудын хил залгаа орших Алтан Хөхийн уул түүний орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Баянхонгор аймгийн Заг сумын нутагт орших Хүрэн бэлчир, Чандмань овоо түүний орчмын газар нутгийг дурсгалт газрын ангиллаар тус тус улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэв.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Дэлгэрхангай уул, Адаацаг сумын нутагт орших Бага газрын чулуу, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын нутагт орших Чойрын Богд уул, Дорноговь аймгийн Мандах, Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт орших Арван найман Богд, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Бүрдний элс, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Малгар, Хавцлын болон баруун, зүүн Төрөнгийн хад, Баяндэлгэр сумын Онгон таван булаг зэрэг газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг тогтоохоор хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэв.

Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 9464.6 га-гийн ойг нөхөн сэргээх ажил гүйцэтгэлийг шалгаж, 7709.6 га талбайд улсын төсвөөр, 191 га талбайд орон нутгийн төсвөөр, 1403 га талбайд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр, 161.4 га талбайд хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжилт хийж, 426 га талбайд “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд байгуулсан ногоон зурвасын ажлыг хүлээн авав.

Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт. “Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүс”, Оюу толгойн ордын усан хангамжийн зориулалтаар ашиглах газрын доорхи усны нөөцөд хийсэн хайгуул судалгааны дүнд түшиглэн усны нөөцийг нь баталгаажуулав.

Газрын доорхи усны 193 ордын бүртгэл, 21 аймгийн 17000 гаруй уст цэгийн тоо бүртгэлийг зохих маягтын дагуу бүртгэж усны мэдээллийн санд авав. Туул голын сав газар, түүний хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийж, газрыг чөлөөлөх асуудлыг 2009-2015 онд үе шаттайгаар хийхээр шийдвэрлэж, ажлыг эхлүүлээд байна.

Агаарын бохирдлыг бууруулах ажил. Нүүрсэн шахмал болон үртсэн түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй 3 жилийн гэрээ хийж, хамтран ажиллаж байна. Тус аж ахуйн нэгж байгууллагууд нь 2008 оны 12 дугаар сар хүртэл нийт 50 гаруй мянган тонн шахмал болон үртсэн түлш үйлдвэрлэж, 20 орчим мянган айл өрхөд нийлүүлсэн байна. Одоогийн байдлаар 70 орчим мянган коксон болон шахмал түлш үйлдвэрлэсэн нь 80 гаруй мянган тонн түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлжээ.

Нүүрсээр галладаг сургууль цэцэрлэгийн халаалтыг цахилгаан халаагуурт шилжүүлснээр үр дүн гарч байна. Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургууль дээр жишээ авч үзэхэд 3 сарын хугацаанд нийт 18.0 сая төгрөгийн буюу 514 тонн түүхий нүүрсний хэрэглээг бууруулсан байна.

Агаарын чанарын хяналт-шинжилгээний суурин харуулыг өргөжүүлж, хөдөө орон нутгийн харуулуудад хүхэрлэг хий, азотын исэл, тоос, угаарын хий гэсэн 4 үзүүлэлтээр агаарын бохирдлыг тодорхойлох боломжийг бүрдүүлж, тоног төхөөрөмжийг суурилуулж эхлэв.

Цаг уурын 2 өртөө, орчны шинжилгээний 2 лаборатори, Агаарын чанарын хяналтын 3 харуул, Мөстөл судлалын болон нуур судлалын станц тус бүр 1-ийг байгуулж, цаг уурын 30 автомат станцыг орон нутагт суурилуулж хэмжилт хийж эхлэв.

Аялал жуулчлал. Зүүн хойд Азийн аялал жуулчлалын 5 дугаар чуулганыг (IFNAT2008) Улаанбаатар хотод зохион байгуулав. Энэхүү чуулганы үр дүнд хил дамнасан хөтөлбөр, “Дорнын тойрог”, “Их цайны зам” маршрутыг хөгжүүлэх, бүсийн нарийн бичгийн газар байгуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэв. “Тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийг боловсруулаад байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт

Эрдэс баялгийн салбарт эрх зүйн орчныг боловсронгуй болгож, татварын ачааллыг багасгах чиглэлээр тодорхой ажлууд хийлээ. “Ашигт малтмалын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал дүгнэлт гаргаж, 1994, 1997, 2006 оны “Ашигт малтмалын тухай” хуулиудын үзэл баримтлал, тухайн үеийн дэлхийн зах зээл дээрх эрдэс түүхий эдийн үнэ, уул уурхайн салбарын нөхцөл байдал, хуулиудыг хооронд нь харьцуулсан судалгаа хийж УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлэв. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийг боловсруулав. Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулах ажлын хэсэг нүүрсний уурхайнуудын санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулах, техник технологийг шинэчлэх асуудлыг судалж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулаад байна. Мөн “Дархан, Сэлэнгэ, Булган, Эрдэнэтийн нүүрсний хэрэгцээг хангах төлөвлөгөөг боловсруулж байна.

Тайширын усан цахилгаан станцын эхний ээлжийг ашиглалтад оруулж, Тайшир сумын төвийн хэрэглээг хангаж байгаа бөгөөд улмаар Говь-Алтай

аймгийн хэрэглэгчдийг хангах туршилтын ажлыг хийж байна. Дөргөний усан цахилгаан станцын 3 турбины /бүрэн хүчин чадлаар/ туршилтыг хийж, мөн түүнийг ОХУ-ын Красноярскийн энерго системтэй зэрэгцээ ажиллуулах туршилтын ажлыг хийж байна.

“Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан УИХ-аар батлуулав. Ингэснээр татвар ногдуулах орлогыг тодорхойлох алтны босго үнийг 850 ам.доллар болгож, уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт ноогдож байсан татварын ачааллыг бууруулахад бодит алхам боллоо.

Ийнхүү алтны босго үнийг өөрчилснөөр алт олборлох үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн Монгол банк болон арилжааны банкуудад тушаах алтны хэмжээ ихсэж улсын валютын нөөц тэр хэмжээгээр өснө. Улсын төсөвт оруулах орлогын хэмжээ нэмэгдэж, алтыг хууль бусаар хил давуулах үйл ажиллагааг таслан зогсоож, алтны хайгуулд зарцуулах, олборлолтын технологийг шинэчлэх, нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ. Түүнчлэн уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгох зэрэг үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн нүүрсний орд, Оюутолгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар УИХ-ын тогтоол гарлаа. Тус ордуудыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт боловсруулж 2009 оны эхээр УИХ-д өргөн мэдүүлэхээр ажилаж байна.

Газрын тосыг гуравдагч орноос импортлохоор БНКаЗУ, АБНЭУ, Кувэйт улсуудад Ажлын хэсэг ажиллаж, БНКаЗУ болон АБНЭУ-тай хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурлаа. “Мон Ойл энд Газ” ХХК “КазМунай Газ” компанитай 2009 оноос эхлэн 5 жилийн хугацаатай БНКаЗУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортлохоор гэрээ байгуулав. Мөн БНХАУ-аас 2009 оноос эхлэн жилд 300 000 хүртэл тонн нефть бүтээгдэхүүн авахаар байгуулсан гэрээний биелэлтийг хангах ажлыг БНКаЗУ, Кувэйт улсаас авах түүхий газрын тостой уялдуулан шийдвэрлэх ажлыг хийж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

Өвөлжилтийн бэлтгэл. 2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах, өвлийг хүндрэлгүй давахад онцгой анхааран ажиллаж байна. Төвийн бүсийн Улаанбаатарын 2, 3, 4, Дархан, Эрдэнэт, Дорнодын дулааны цахилгаан станцуудын хувьд өвөлжилтийн бэлтгэл үндсэндээ хангагдсан. Түлшний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц нийт дүнгээрээ 85.0 хувийн биелэлттэй байна. Нүүрсний нөөц нийт 870.0 мянган тонн байгаа нь станцуудын өвлийн улирлын нүүрсний хэрэгцээг хангах боломжтой гэж үзэж байна. Дулааны цахилгаан станцуудын нүүрсний нөөцийг өвлийн их ачааллын үед 20 хоногийн нөөцтэй буюу 260,0 мянган тонн байлгахгаар төлөвлөсөн ба 12 дугаар сарын 5-ны байдлаар 277,0 мянган тонн нүүрс нөөцлөөд байна.

Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд хүн ам, барилга, байшингийн төвлөрөлт нэмэгдэж байгаатай холбогдон цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ огцом нэмэгдэж байна. Умард дэд станцад 110/6 кВ-ын 16000 кВа чадалтай трансформаторыг нэмж суурилуулснаар ачааллыг бууруулж хэвийн

ажиллагаанд шилжүүлээ. 110 кВ-ын Дорнод-2 дэд станцын ажиллагааг хэвийн болгохоор уг станцаас тэжээгдэж байсан 7 буудал орчмын хэрэглэгчдийг 110 кВ-ын Умард дэд станцаас хуучин хэрэглэж байсан шугамаар тэжээснээр ачааллыг хөнгөлж хязгаарлалтын горимыг цуцалж хэвийн болголоо.

Улаанбаатар хотод эрчим хүчний шинэ эх үүсвэр барих нээлттэй тендерт оролцогч компаниудаас ирүүлсэн саналын үндсэн дээр тендер нээх хугацааг 2009 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сунгасан. Шинэ эх үүсвэрийн цахилгаан, дулааны шугам, төмөр зам, цэвэр бохир усны шугам зэрэг инженерийн байгууламжийг барих газрын асуудлаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

Эрчим хүчний салбарын нэгдсэн бизнес төлөвлөгөө боловсруулж, санхүүжилт, хөрөнгө оруулалтын тооцоог хийж байна. Эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, эрчим хүчний салбарын эрдэмтэд, төрийн бус байгууллага, хувийн болон төрийн өмчит үйлдвэрийн газрын төлөөлөгчдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулав. Энэхүү бодлогын баримт бичиг боловсруулах явцад эрчим хүчний салбарын хэмжээнд шаардагдаж буй 85,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын хэмжээ, хөрөнгө оруулалтын тооцоог гаргав.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлогын зөвлөгөө өгөх, удирдамжаар хангах, санал дүгнэлт боловсруулж танилцуулах, стратегийн төлөвлөлт боловсруулах, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Бодлогын Зөвлөлийг байгуулав. Бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнд эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын төлөөлөл орсон болно. Төр, ТББ, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд тус зөвлөлийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт

Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Хөдөө аж ахуйн техникийн талаар баримтлах бодлого”, “Мах, сүүний хангамжийг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай”, “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”, “Орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал, шимт тэжээллэг чанар” Үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичгийг боловсруулав.

Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, чанар, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дотоодын үйлдвэрийн 100.0 мянган тонн улаан буудайгаар хүнсний стратегийн нөөц бүрдүүлэх, дотоодод үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд эдгээр асуудал шийдвэрлэгдэх шатанд хэлэлцэгдэж байна.

Мөн ОХУ-аас импортолсон 100.0 мянган тонн улаан буудайн НӨАТ болон Гаалийн татварыг чөлөөлөх хугацааг сунгах асуудлыг УИХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн нь гурилын хангамжийг сайжруулж, үнийг тогтворжуулахад чухал нөлөө үзүүлэх болно.

Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын доноруудын тусламжтайгаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар 2009-2012 онд баримтлах бодлого, арга хэмжээний саналыг боловсрууллаа.

Орон нутагт сүү боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хоногт 200 литр сүү хөргөж савлах жижиг цех 22 ширхэг, сумын төвийн нөхцөлд

хоногт 500-1000 литр сүү боловсруулах жижиг цех 4, аймгийн түвшинд хоногт 1000-5000 литр сүү хүлээн авч хөргөх чадалтай сүүний хөргөлтийн төв 20 ширхэгийг тус тус худалдан авч, Улаанбаатар хот, аймгийн төвийн орчмын саалийн аж ахуйд нийлүүлэв.

Хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс сүү, сүүн бүтээгдэхүүнд агуулагдах хорт бодисын агууламжийг тогтоох лабораторийн тоног төхөөрөмж, оношлуурыг худалдан авахад шаардагдах 113.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, сүү, сүүн бүтээгдэхүүн, үхэр, гахай, шувууны тэжээлд меламина тодорхойлох чадавхи бүрдүүлээ.

Ургац хураалтын ажлыг цаг хугацаанд нь дуусгаж, 2008 онд 205.8 мянган тонн үр тариа, 142.1 мянган тонн төмс, 80.6 мянган тонн хүнсний ногоо, 5.4 мянган тонн тосны ургамал, 15.7 мянган тонн малын тэжээлийн ургамал хурааж авсныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад үр тариа 91.2 мянган тонн, төмс 28.5 мянган тонн, хүнсний ногоо 1.5 мянган тонноор тус тус илүү байна. Үүний үр дүнд жилийн хэрэгцээт буудайн 50 хувь, хүнсний ногооны 49 хувь, төмсний нийт хэрэгцээг дотоодын ургацаар бүрэн хангах боломжтой болов.

“Хүнс, хөдөө аж ахуйн намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээг Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулж, 14 аймгийн 51 сум, нийслэлийн 6 дүүргийн 181 иргэн, аж ахуйн нэгж оролцож, 23 нэр төрлийн 3372.0 тонн төмс, хүнсний ногоо, 17440 шил даршилсан ногоо, 2.0 тонн зөгийн бал, 15400 ширхэг суулгац борлуулж, 1.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийлээ. Арга хэмжээний үеэр “Шилмэл мал-2008” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, гойд ашиг шимт 313 малыг худалдан борлуулав.

“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1044 аж ахуйн нэгж, иргэнд 4.0 тэрбум төгрөгийн шатахууныг зээлээр олгож уринш бэлтгэхэд дэмжлэг үзүүлснээр улсын хэмжээнд 256.4 мянган га-д чанар сайтай уриншийн боловсруулалт бэлтгэж төлөвлөсөн зорилтоо 102.2 хувиар биелүүллээ. Мөн өндөр хүчин чадлын 100 трактор, 80 ширхэг төмсний иж бүрдэл бүхий трактор, 41 комбайныг дагалдах тоноглол хэрэгслийн хамт 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 160 гаруй аж ахуйн нэгж, иргэнд олгов. Ингэснээр 120.0 мянган га эргэлтийн талбайд ажиллах техникийн хүчин чадлыг бүрдүүллээ.

Гурилын үйлдвэрт тушаасан дотоодын үйлдвэрлэлийн буудайн тонн тутамд 80.0 мянган төгрөгийн урамшуулал олгох, аж ахуйн нэгж, иргэдээр 2009 оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний үр нөөцлүүлэх, гадаадын зээл, тусламжийн буудайг хүлээн авч байршуулах, газар тариалангийн салбарт өр авлага барагдуулах зэрэг ажлыг амжилттай зохион байгуулж хэрэгжүүлэв.

Улсын нөөц болон Тариалан эрхлэлтийг дэмжих сан, гурилын үйлдвэрт 130.0 гаруй мянган тонн буудай тушаасан 355 аж ахуйн нэгж, иргэнд 10.6 тэрбум төгрөгийн урамшуулал олгох ажлыг зохион байгуулж байна.

2009 оны тариалалтад зориулж тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд 23,5 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих санд 9.0 мянган тонн, Улсын нөөцөд 3.0 мянган тонн үр нөөцлөв. Өр авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, 5.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлэв.

Энэ жилийн төсөл шалгаруулалтад тэнцэж, гэрээ байгуулсан 37 услалтын системийг шинээр байгуулж, 22 системийг сэргээн засварлах ажлыг дуусгаж ашиглалтад хүлээн авлаа. Өрхийн аж ахуйн эзэмшлийн 10 хүртэл га талбайг усжуулах хэмжээний 28 услалтын систем барьж, засварлан ашиглалтад оруулсан иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь цаашид айл өрх, иргэн бүр эрсдэл багатай тариалангийн үйлдвэрлэл эрхлэх урам зоригийг

сэргээсэн арга хэмжээ болов. Усалгаатай тариалан эрхлэх боломжтой талбайн болон усны нөөцийн судалгааг 40.0 мянган га талбайд зохион байгуулав.

Мөн хамгаалагдсан хөрсний тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор сумдад агропарк байгуулахад санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэв.

Малчдын мөнгөн орлогын гол эх үүсвэр болсон ямааны ноолуурын үнийн зөрүүг нөхөн олгуулах асуудлыг боловсруулан УИХ-ын чуулганаар шийдвэрлүүлж, мөнгийг олгох ажлыг зохион байгуулж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Говьсүмбэрийн Малахын тал, Говь-Алтайн Аргалант, Завхан аймгийн Багахайрханы аймаг дундын отрын бүс нутагт бэлчээрийн даац тогтоон, эдгээрт 2008-2009 онд өвөлжиж, хаваржуулах малын тоо толгойг тодорхойлж, 9 аймгийн 27 сумын 490 өрхийн 360.0 мянган малыг өвөлжүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн тусгай хамгаалалттай бүс нутагт 14 аймгийн 43 сумын 553.9 мянган мал, хилийн бүс, зурвас газарт 14 аймгийн 2000 өрхийн 500.0 мянган малыг өвөлжүүлж, хаваржуулах асуудлыг шийдвэрлэв.

Аймаг дундын отрын бүс нутагт 130 га талбайг хашиж хамгаалан усалгаатай хадлан, таримал тэжээл тариалах боломж бүрдүүллээ. Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 50.4 га талбайг усжуулах услалтын систем байгуулан ашиглалтад хүлээн авлаа.

Отрын мал сүргийг эрсдэлээс хамгаалах зориулалтаар бага оврын тэжээлийн цех 2-ыг байгуулж, багсармал тэжээл үйлдвэрлэж байна.

Энэ онд шинээр 520 худаг барьж байгуулан 192 худгийг засч сэргээн ашиглалтад хүлээн авав. Мөн 10 аймагт 500 уст цэгийн геофизикийн хайгуул хийлгэлээ.

Бэлчээрийн хортон үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй аргаар тэмцэх намрын устгалыг нийт 350.0 мянган га талбайд зохион байгуулав.

Дорнод аймагт гарсан олон улсын хорио цээр бүхий гоц халдварт ямааны цэцэг өвчинтэй тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, голомтыг аюулгүй болгон хяналтад оруулж, 55,9 мянган ямааг дархлаажуулах арга хэмжээ авлаа.

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүү, махны өндөр ашиг шимтэй үхрийг гадаад, дотоодын зах зээлээс бэлтгэн Улаанбаатар хот болон хүн ам олноор суурьшсан бүс нутагт загвар фермерийн аж ахуй байгуулах, тэдгээрт санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэй зээлээр олгох ажлыг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохион байгуулж, 400 үхрийг 26 төсөлд хуваарилан олгож, 1063.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

Мөн төв суурин газрын ойролцоо эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй 49 аж ахуйн нэгж, иргэнд нийт 200.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг 3 жилийн хугацаатай үзүүлэв.

Төвийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх ажлыг Сэлэнгэ, Төв аймагтай хамтран хэрэгжүүлж эхэллээ.

Мах-сүүний үхрийн зохиомол хээлтүүлгийн 39 салбар ажиллуулж 3020 үнээнд гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэг хийв. Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн сүүний чиглэлийн эрчимжсэн 232 аж ахуйн 4200 үнээг үржлийн бүртгэлд хамруулж сүүний үхрийн гарваль, ашиг шимийн мэдээллийн санг бүрдүүллээ.

Бог малын зохиомол хээлтүүлгийн 38 салбар ажиллуулан үр үйлдвэрлэх болон гүн хөлдөөсөн үр ашиглах замаар 8568 малд зохиомол

хээлтүүлэг хийлээ. Куба улсаас импортолсон сүүний чиглэлийн Заанен, Альпин үүлдрийн ухнын үрээр 1310 эм ямааг хээлтүүлэв. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн захиалгаар цөм сүргийн 1180 хээлтэгч, хээлтүүлэгч нийлүүлээ.

Мөн гахай, шувууны аж ахуй эрхлэх санаачлагыг дэмжиж махны үүлдрийн 165 толгой үржлийн гахайг 18 иргэн, аж ахуйн нэгжид 2 жилийн хугацаанд бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар буцаан төлөх нөхцөл бүхий гэрээгээр олгов. Өндөглөгчийн сүрэг сэлбэх зориулалтаар 30000 ширхэг үржлийн тахианы өндөг импортоор оруулж ирж инкубаторт дарах ажлыг зохион байгууллаа.

Малын тэжээл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хоногт 3-5 тонн тэжээл үйлдвэрлэх 12 иж бүрдэл цехийн тоног төхөөрөмжийг Улаанбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Булган аймгийн тодорхой нөхцөл, шаардлага хангасан 12 иргэн, аж ахуйн нэгжид үнийн дүнг 50 хувь хөнгөлөн олгов.

Говь-Алтай, Завхан аймагт Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн үйл ажиллагааг эхлүүлээ.

Улаанбаатар хотын бүсэд 2009-2012 онд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр 25-30 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 10-12 мянган тонн мах бэлтгэх “махны нөөцийн сан”, 50-100 үнээний 40 аж ахуй, махны худалдааны төрөлжсөн бирж, 120000 м² талбай бүхий хүлэмжийн аж ахуй, төмс, хүнсний ногоо хадгалах 30.000 тоннын багтаамж бүхий механикжсан зоорь байгуулах ажлыг зохион байгуулж эхлэв. Шинэ технологийг нутагшуулах, үйлдвэрүүдийг сүүлийн үеийн мэдээллээр хангах зорилго бүхий Технологи дамжуулах төвийг Улаанбаатар хотод байгуулав. Мөн нийслэлд “Санхүүгийн түрээсийн төв”, бүх дүүрэгт “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул дүүрэгт үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар ажиллаж байна.

Батлан хамгаалах салбарт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барив. Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж байна.

“Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэв. Эдгээр хууль тогтоомжууд батлагдсанаар батлан хамгаалах салбарын хууль тогтоомж улам боловсронгуй болж, “Зэвсэгт хүчний хөгжлийн сан” байгуулах эрх зүйн үндэс бүрдэж, уг санд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багийг оролцуулсны нөхөн төлбөр, гадаадын тусламж, бусад орлогыг төвлөрүүлж, Зэвсэгт хүчний тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болох юм.

“Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр”, “Энхийг сахиулах ажиллагаанд оролцох анги, салбаруудын зэвсэглэл техникийг шинэчлэх” дэд төсөл, “Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв” төслийг тус тус батлан мөрдөж байна.

БНЭУ-д болсон “Нүүдэлчин заан-2008” Энэтхэг-Монголын цэргийн тусгай хүчний хамтарсан хээрийн сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 27 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн баг, Катар Улсад зохион байгуулагдсан “Догшин шонхор” олон улсын сургалт, дадлагад 3 цэргийн албан хаагч тус тус амжилттай оролцлоо.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн хамтарсан “Дархан-1” энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагыг зохион

байгуулж, Зэвсэгт хүчний зарим ангиудын авто, хуягт танкийн техник, зэвсэглэл, холбоо, инженер, агаарын довтолгооноос хамгаалах техникт засвар үйлчилгээ, эталон хэмжих хэрэгсэлд засвар, баталгаажилт хийсний үр дүнд Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд ахиц гарч, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэв. Энэ нь цаашид зэвсэглэл техникийн засвар, үйлчилгээ хийх тодорхой хэмжээний сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлсний зэрэгцээ Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний зэвсэглэл, техникт засвар, үйлчилгээ хийх дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ.

Иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлэх журмын дагуу 65 иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлж, 2008 оны II ээлжийн цэрэг таталт, 2007 оны II ээлжийн цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг халах ажлыг зохион байгуулав. Энэ удаагийн цэрэг татлагын дүнгээс харахад цэргийн насны залуучуудын цэргийн алба хаах дур сонирхол нэмэгдсэн, цэргийн насны залуусын эрүүл мэнд болон боловсролын түвшин ахиж, өмнөх цэрэг татлагатай харьцуулахад эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанаас чөлөөлөгсөд 1.2 хувиар буурч, тусгай дунд болон дээд боловсролтой хүний тоо 1.4 хувиар өссөн нь хүн амын дунд Зэвсэгт хүчний нэр хүнд өсч байгааг тодорхой хэмжээгээр харуулж байна.

Батлан хамгаалахын залуу эрдэмтэн судлаачдын анхдугаар чуулганыг зохион байгуулав. Цагаатгах ажлыг зохион байгуулах улсын комисс, Тагнуулын ерөнхий газартай хамтран “Улс төрийн хэлмэгдэлт-Монгол ардын цэрэг” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Иракийн сэргээн босголтын ажиллагаанд оролцсон 10 дахь ээлжийн бүрэлдэхүүнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд нар, Батлан хамгаалахын болон цэргийн атташегийн аппарат бүрэн бүрэлдэхүүнээрээ, гадаадын бусад төлөөлөгчид оролцлоо.

Цэргийн сургалт бэлтгэлийн шинэ тогтолцооны дагуу Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний нийт анги, салбаруудад 2008-2009 онд явуулах сургалт бэлтгэлийн ерөнхий төлөвлөгөөг батлаж, сургалтыг зохион байгуулж байна.

Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудад нууц-архивын эрхлэгчийн орон тоо батлагдсантай холбогдуулан тухайн албан тушаалд томилох албан хаагчдыг судалж, шийдвэрлүүлэв.

2008 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 2 нэгж Ми-171 Е загварын нисдэг тэргийг Улсын комисст болон анги байгууллагад нь хүлээлгэн өгч, ашиглалтад орууллаа.

НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцогч цэргийн албан хаагчдад зориулсан 50 айлын албан тушаалын орон сууц, Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооллын 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж байгаа 2 дахь 37 айлын орон сууц, Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн байрлалд баригдаж байгаа цэргийн албан хаагчдын 50 айлын орон сууцны барилгын угсралтын ажлыг дуусгав.

Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн спорт заал, Өмнөговь аймаг дахь Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн байрлалд баригдаж байгаа цэргийн албан хаагчдын 20 айлын орон сууц, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн эмнэлгийн байр, 12 айлын орон сууц, Увс аймгийн Зүүнговь сум дахь Зэвсэгт хүчний 328 дугаар салбарын штабын байрны болон 5 автомашины гаражийн засвар, Зэвсэгт хүчний 084, 065 дугаар ангиудын гадна инженерийн шугам сүлжээний засварын ажлыг тус тус дуусгаж, ашиглалтад орууллаа.

АНУ-ын тусламжаар Зэвсэгт хүчний 330 дугаар ангид 20 хүний суудалтай англи хэлний иж бүрэн танхимыг байгуулж, ашиглалтад орууллаа.

Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгуудад Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаа байдал, тус аймгуудын Засаг даргын тамгын газар, Цэргийн штабуудын үйл ажиллагаа, Зэвсэгт хүчний 9 анги салбарын зэвсэг, галт хэрэгслийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, зарцуулалт, бүртгэл тооцооны үйл ажиллагаанд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох шийдвэрийг гарган хэрэгжүүлж байна.

Гамшгаас хамгаалах талаар

“Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах, хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх журам”, “Гамшгаас хамгаалах талаар баримтлах төрийн бодлого, хөтөлбөр”, “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслүүдийг боловсруулав. Мөн Онцгой байдлын албаны “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв” байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Онцгой байдлын албаны Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг боловсруулж байна.

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “KOICA”-гийн шугамаар Гамшгийн судалгаа, шинжилгээний төвд хэрэгжиж буй төслийн хүрээнд хийгдсэн ажлыг хүлээлцэх арга хэмжээг зохион байгууллаа.

Сургалт, сурталчилгаа. Аймаг, нийслэл, дүүргүүдийн аврах, гал унтраах ангиудын салааны захирагч нарын сургалтад 166 хүнийг хамрууллаа. Мөн ОХУ-ын Эрхүү мужийн “Байгаль” дахь аврагч бэлтгэх төвд 32 аврагчийг усчин-аврагчийн чиглэлээр сургалтад хамруулсан ба мөн төвд аврагч-гал сөнөөгч 11 хүн 14 хоногийн сургалтад хамрагдлаа.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “МОН/08/05” төслийн багтай хамтран химийн хорт бодистой тэмцэх сургалтыг зохион байгуулж, төв орон нутгийн 38 аврагч-химичдийг оролцууллаа. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нарыг шинээр бэлтгэх, давтан сургах сургалтыг зохион байгуулж аймаг, нийслэл, дүүргийн нийт 108 албан хаагч хамрагдлаа.

Гамшгийн цаг үеийн нөхцөл байдлын мэдээг төвийн телевиз, сонин, радиогоор 225 удаа давтамжтайгаар гаргаж мэдээллээ. Мөн гамшгийн нөхцөл байдлын талаархи мэдээ, мэдээллийг төвийн 12 сонин, 10 телевизийн сувгаар 300 гаруй удаа нэвтрүүлээд байна.

Иргэдэд гамшгийн талаар мэдлэг, ойлголт өгөх, гамшгаас урьдчилан сэргийлэх уламжлалт арга ухаанд сургах зорилгоор “Боловсрол суваг” телевизтэй хамтран “Дөрвөн өнгө” нэвтрүүлгийг 4 удаа явуулав.

“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх ажлыг сайжруулъя” онол практикийн бага хурал зохион байгуулж зөвлөмж гаргав.

Аврах, гал унтраах ангийн салааны захирагч нартай “Ой хээрийн болон объектын түймрийг унтраах арга ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулж, нийслэл, аймгийн Аврах гал унтраах ангийн нийт 166 салаан захирагчийг 4 ээлжээр сургалтанд хамруулав.

Урьдчилан сэргийлэх үзлэг, хяналт. Нийслэлийн 9 дүүргийн 12 аврах, гал унтраах ангиудын бэлтгэл, бэлэн байдалд үзлэг хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулж, холбогдох заавар, зөвлөмж өгч ажиллав. Мөн нийслэл болон орон нутгийн хэмжээнд 28735 айл өрх, 1995 аж ахуйн нэгж, байгууллагад гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт хийж, гал түймэр гарч болзошгүй 15896 зөрчлийг илрүүлэн шалгалтын явцад 6068 зөрчлийг арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар Заавал биелүүлэх албан шаардлага 353, Мэдэгдэл 147,

Танилцуулга 14-ийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд 18 удаа оролцож, 3 барилгыг ашиглалтад хүлээн авч, 26 барилгын зурагт хяналт хийж, 8 барилгын норм, дүрэм, стандарт зөрчсөн зөрчлүүдийг арилгуулах талаар заавар зөвлөгөө өглөө.

Улсын нөөц бүрдүүлэлт, сэргээн босголт. 2008 онд улсын нөөцөд нөхөн бүрдүүлэх үйлдвэрлэл, техникийн барааны жагсаалтыг гарган батлуулж, нийт 3 багц 405,8 сая төгрөгийн автомашин, гэр, тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлаж, нөөц бүрдүүлэлт хийлээ.

Шатахуун тосолгооны материалын нөөцөд Төсвийн санхүүжилт болон борлуулалтын 1861,6 сая төгрөгийн дизель түлш, 1513,4 сая төгрөгийн А-80 автобензин, 824,9 сая төгрөгийн Аи-92 автобензин, нийт 4199,9 сая төгрөгийн шатахуун бүрдүүлээд байна.

Улсын нөөцийн тухай хуулийн биелэлтийг хангах, мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд улсын нөөцийн өвсний бүрдүүлэлт 68.5 хувь, тэжээлийн бүрдүүлэлт 84.5 хувийн гүйцэтгэлтэй /Засгийн газрын 2008 оны 249 дүгээр тогтоолд заасны дагуу/ байна.

Засгийн газраас гаргасан улаан буудайн нөөц бүрдүүлж гурилын хангамжийг нэмэгдүүлэх шийдвэрийн дагуу улсын нөөцийн 9 салбарт 2008 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 33.8 мянган тонн хүнсний улаан буудай, 4.1 мянган тонн үрийн улаан буудай худалдан авч нөөц бүрдүүлээд байна.

2008 онд улсын нөөцөөс 3454,8 тонн улаан буудайн үр, 312,6 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний бараа бүтээгдэхүүн, 565,4 сая төгрөгийн өвс, 670,9 сая төгрөгийн тэжээл, 2157,12 тонн газрын тосны бүтээгдэхүүн, 296,8 сая төгрөгийн үнэ бүхий өргөн хэрэглээ, үйлдвэрлэл техникийн бараа, нийт 5999,8 сая төгрөгийн бараа материалыг борлуулж тухайн барааны нөөц нөхөн бүрдүүлэлтэд зарцууллаа.

Гадаад харилцааны салбарт

Дээд хэмжээний дипломат ажиллагааны талаар. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНХАУ-ын Бээжин хотод болсон Ази-Европын дээд хэмжээний уулзалт (АСЕМ), АНУ-ын Нью Йорк хотод зохион байгуулагдсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Алматын үйл ажиллагааны хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийг хянан хэлэлцэх өндөр түвшний хуралдаан, Франц Улсын Эвиан хотноо болсон “Дэлхийн бодлого” Олон Улсын Бага хурал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконг хотноо АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтонь санаачилгаар зохион байгуулагдсан “Дэлхийн санаачилга” уулзалтад тус тус оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Бүгд Найрамдах Болгар Улсад төрийн айлчлал хийв.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч нар Монгол Улсад айлчлав.

Бүгд Найрамдах Турк Улсын Шадар сайд бөгөөд Төрийн сайд Хаяати Языжы, Швейцарийн Холбооны Улсын Үндэсний Зөвлөлийн дарга А.Буньон, Их Британи Умард Ирландын Нэгдсэн вант Улсын Парламентын төлөөлөгчид, Йоркийн гүн хунтайж Эндрю, Люксембургийн Их Гүнт Улсын Ерөнхий сайд Ж.К.Юнкер, Норвегийн Вант Улсын угсаа залгамжлах ханхүү Х.Хаакон, ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Засгийн газрын дарга Б.Сенгелеев тэргүүтэй төлөөлөгчдийн айлчлалыг тус тус зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Дэмбэрэл БНХАУ, БНЛаос Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын уулзалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 63 дугаар чуулганд оролцож, БНСУ-д албан ёсоор айлчиллаа.

Монгол, Орос болон Монгол, Хятадын ЗГХК-ын дарга нарын Москва, Бээжин хотноо тус тус хийх албан уулзалтын асуудлыг шийдвэрлүүлэв.

Австрали улсад суух Элчин сайдыг томилуулж, үүрэгт ажилд нь оруулж, тус улсын Канберра хотод ЭСЯ-ыг албан ёсоор нээв.

Гадаад бодлогыг эдийн засагжуулах зорилтын хүрээнд. Монгол Улсад үүсээд байгаа санхүүгийн хямралын гадаад шалтгаанд дүгнэлт хийж, түүнээс гарах арга замын талаарх бусад орны туршлагыг судалж байна. Энэхүү асуудлыг өндөр, дээд хэмжээний айлчлалын үеэр байнга хөндөн ярьж, зөвлөлдөн манай томоохон төслүүдийг санхүүжүүлэх гадны эх үүсвэр олох зорилт тавин ажиллаж байна.

Газрын тос импортлох, бензин, шатахууны импортыг нэмэгдүүлэх талаар өндөр, дээд хэмжээнд ярьсан, тохиролцсон асуудлуудыг урагшлуулахаар холбогдох улс орнуудтай яриа хэлэлцээ үргэлжлүүлэн хийж байна.

“Гадаад худалдааны бодлого, дунд хугацааны үзэл баримтлал”-ын төслийн талаар үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Европын Холбооны хөнгөлөлтийг 2009-2011 онуудад үргэлжлүүлэн эдлэх талаар Монгол Улсын Засгийн газрын албан ёсны хүсэлтийг Европын Комисст хүргүүлж, улмаар хөнгөлөлт эдлэх асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

“Импортын зарим нэрийн савласан бараа, бүтээгдэхүүний шошгыг монгол хэл дээр бичиж, дотоодын зах зээлд нийлүүлэх, худалдаалах тухай” техникийн зохицуулалтын асуудлыг Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлж, гишүүн орнуудын саналыг авах хүсэлтээ илэрхийлээд байна.

ОХУ-ын Москва хотноо болох Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулах транзит тээврийн тухай 3 талт хэлэлцээрийн хавсралтуудыг тохиролцох VIII хэлэлцээнд оролцохоор ажиллаж байна.

НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс болон Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай хамтран “Оюуны өмчийн эрх ба худалдаа” сэдэвт бүс нутгийн дээд хэмжээний Дугуй ширээний уулзалт, ДХБ-тай хамтран “Худалдаан дахь техникийн саад тотгорууд”, “Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуй” сэдэвт Үндэсний семинар, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нийгмийн хөгжлийн салбарт нэвтрүүлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сан, Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Үндэсний семинарыг тус тус зохион байгууллаа.

“Бичигтэн болох НҮБ-ын 10 жил”, “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг тус тус батлуулав.

Олон улсын баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай Конвенцийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв.

БНСУ-д зорчиж байгаа монгол иргэдэд олгодог визийн хугацааг 90 хоног болгох талаар солонгосын талтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад монгол иргэд зорчих асуудлыг цогцоор нь авч үзэн, талуудтай хэлэлцээ хийх чиглэл гаргав.

Хууль, эрх зүйн салбарт

Стратегийн удирдлагын хүрээнд. Баталсан тов, дараалал харгалзахгүйгээр улсын эдийн засаг, нийгмийн нэн яаралтай шийдвэрлэх асуудлыг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай болон Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Дээрхи хуулиудыг УИХ-ын чуулганы 2008 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд дэлхийн улс орнуудад нүүрлээд байгаа санхүүгийн хямралаас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлаар Засгийн газраас үр дүнтэй арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх боломжтой болов.

Мөн банк, санхүүгийн байгууллагууд ипотекийн зээл олгоход шаардагдах хөрөнгийн нэмэлт эх үүсвэрийг олон улсын санхүүгийн зах зээлээс татах боломж бий болгох, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, түүний хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийг боловсруулав. Эдгээр хууль батлагдан гарснаар, иргэд урт хугацаатай орон сууцны зээл авах, банк, санхүүгийн байгууллагууд хөрөнгийн нэмэлт эх үүсвэр олох боломжтой болно. Ингэснээр дэлхийн улс орнуудыг хамраад байгаа эдийн засгийн хямралаас урьдчилан сэргийлэхэд тус дөхөм болох эрх зүйн үндэс бүрдэх юм.

Түүнчлэн 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдлын улмаас амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон хохирогчдод нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлүүлэхээр Хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулийн төсөл боловсруулав.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, тус байгууллагын бүтэц, орон тоог шинэчилж батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулж, холбогдох байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулж байна.

Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Улсын Ерөнхий прокурорын газар болон түүний дэргэдэх Мөрдөн байцаах албаны байрыг төрийн тусгай хамгаалалтанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Удирдлага, зохицуулалтын хүрээнд. Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор баталсан “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийв. Энэ хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр эрүүгийн хэрэгт холбогдсон нэн ядуу, ядуу буюу төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур амьдралтай иргэдэд Үндсэн хуульд заасан өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг баталгаатай эдлүүлэх талаар ахиц гарч байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 5 дахь илтгэл, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын илтгэлийг боловсруулав. Ингэснээр Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Монгол Улс дахь иргэний болон улс төрийн эрхийн, түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эрх зүйн орчинд бодитой дүгнэлт өгөх боломж бүрдэх юм.

Хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэг, хөдөлгөөнд оролцох дадал олгох, хүүхэд зам тээврийн осол, хэрэгт өртөж амь нас, эрүүл

мэндээрээ хохирох явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд-Замын хөдөлгөөн” сэдэвт арга хэмжээг 2008 оны 11 дүгээр сард зохион байгуулав.

Хил хамгаалах ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон шинэчилж, Хөвсгөл аймгийн “Их ямаат”-ын хилийн застав болон хилийн 0306 дугаар ангийн “Бага хүрээ”, хилийн 0275 дугаар ангийн “Эрээн цав”, хилийн 0277 дугаар ангийн “Хачиг”-ийн заставуудад шинээр баригдсан барилгуудыг ашиглалтад хүлээн авлаа. Мөн АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Хил хамгаалах байгууллагын холбоог сайжруулах” төслийн хүрээнд 1.6 сая ам.долларын өртөг бүхий холбооны тоног төхөөрөмжийг хүлээн авч, хилийн 1 отряд, 12 застав, байнгын 3, хөдөлгөөнт 3 хилийн харуулд суурилуулан хил хамгаалалтад шилжүүлэв.

Төвлөрсөн 11 хорих анги, шийдвэр гүйцэтгэлийн 1 албанд нийт 12 байрыг, мөн хорих 429 дүгээр ангид 120 ортой эмнэлгийн байрыг барьж дуусган, ашиглалтад хүлээн авлаа. Энэ нь ялтныг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлд ял эдлүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, ялтанд хийх эмчилгээг эмнэлгийн тусламж үйлчилгээний стандартын шаардлага хангасан нөхцөлд үзүүлэх боломжийг хангасан арга хэмжээ боллоо.

Ялтнуудыг нийгэмшүүлэх буюу ял эдэлж дууссаны дараа хэвийн ажиллаж, амьдрах чадвартай болгох ажлын хүрээнд “Мэргэжлийн түр сургалтын төв”-ийг байгуулах ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэв. Тухайлбал, Амгалан дахь Хорих 421 дүгээр ангид Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг бүрэн дуусгаж, Баянзүрх дэх Хорих 407 дугаар ангид оёдол-эсгүүр, нэхмэл, Зайсан дахь Хорих 401 дүгээр ангид алт, мөнгөний дархан, сийлбэр зэрэг чиглэлээр Мэргэжлийн түр сургалтын төв байгуулах бэлтгэл ажлыг хангав.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэг, санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Иргэний бүртгэлийн улсын нэгдсэн сүлжээ” төслийн хүрээнд 21 аймгийн Иргэний бүртгэл, мэдээллийн алба, Нийслэлийн иргэний бүртгэл, мэдээллийн алба болон Нийслэлийн 9 дүүргийн иргэний бүртгэл, мэдээллийн тасгийг ИБМУТ-тэй шилэн кабелиар холбож, тоног төхөөрөмж суурилуулах ажлыг хийж гүйцэтгэв. Ийнхүү Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн цахим санг бүрдүүлэх, иргэний бүртгэлийн давхардал, зөрчлийг арилгах, мэдээллийг үнэн бодитой шуурхай солилцох боломжтой болов.

Мөн Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангийн нууцлалыг өндөржүүлэх, аюулгүй байдлыг хангах үүднээс системийн хэмжээнд ашиглаж байгаа компьютерүүдийг төвлөрсөн удирдлага, хяналтын нэгдсэн тогтолцоотой болгох зорилгоор хамгийн сүүлийн үеийн хяналтын системийг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд нэвтрүүлэв.

“Иргэний бүртгэл-паспорт, хяналтын нэгдсэн сүлжээ” төслийн хүрээнд хилийн 20 боомтыг холбож, сансрын Висат системийн антенг суурилуулсан бөгөөд Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албыг шилэн кабелиар, Замын-үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Буянт-Ухаа боомтыг сансрын холбооны “Висат” системийг ашиглан тус тус холбож, харилцан мэдээлэл солилцож байна.

Мэргэжлийн хяналт, шалгалт

Мэргэжлийн хяналтын менежментийг шинэ шатанд гаргалаа.

Улс, аймаг, нийслэлийн болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж, удирдлагын шат дамжлагыг цөөрүүлж, зохион байгуулалтын хувьд цомхон болгож, нийслэлийн дүүргүүдэд төрийн хяналтын нэгжийг байгуулсны зэрэгцээ хяналтын ажлын чиг үүргийг чиглэл тус бүрээр

нарийвчлан тогтоож өгснөөр төвлөрлийг сааруулж, ажил үүргийг оновчтой болгож, хүнд суртал, давхардал чирэгдлийг арилгах, хяналтын үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүллээ.

УМХГ-ын дотоод үйл ажиллагааг зохицуулсан 31 дүрэм, журмыг дахин нягтлан судалсны үндсэн дээр 17 дүрэм журмыг шинэчилж, 2 журмыг хүчингүй болгож, 2 журмыг шинээр боловсруулж мөрдүүлснээр дотоодын эрх зүйн зохицуулалт сайжирч, албан хаагчдын эрх, үүргийг оновчтой болгож, сахилга хариуцлагыг өндөржүүлэв.

Хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын орон тоог 150, үйлчилгээний ажилтны орон тоог 10-аар нэмэгдүүлж, хилийн хяналтын албадыг боловсон хүчнээр хангах арга хэмжээ авснаар импортын бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих хяналт шалгалтын хүртээмж, шуурхай байдал эрс дээшлэх боломж бүрдэв.

Иргэний нисэх, төмөр зам, тусгай хамгаалалттай газар нутаг, нийтийн тээвэр зэрэг салбаруудад 270 гаруй гэрээт байцаагчдыг ажиллуулснаар төрийн хяналтын үйлчилгээний хүртээмж сайжирч, шалгалтын ажлын үр дүн дээшилж байна.

Улсын хяналтын албад, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын улирал, хагас жилийн ажилд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгдөг болсны зэрэгцээ 15 аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын 2 албаны дотоод ажлын зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, ололт амжилтыг тодорхойлж, алдаа дутагдлыг засч залруулах үүрэг даалгавар өглөө.

Материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр дорвитой ахиц гаргав. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2.1 тэрбум, Засгийн газрын нөөц хөрөнгийн 113.7 сая төгрөгөөр лабораторийн тоног төхөөрөмж, хяналт шалгалтын багаж хэрэгсэл худалдан авч, төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудад хуваарилан хүргүүлснээр Нэгдсэн төв лабораторид хүнсний аюулгүйн үзүүлэлтийн 70 хувийг шинжилдэг байсныг 90 хувьд, орон нутгийн лабораториудад хүнсний аюулгүйн үзүүлэлтийн 30-40 хувийг шинжилдэг байсныг 50-60 хувьд хүргэсний зэрэгцээ Нэгдсэн төв лабораторид цианид, мөнгөн усны агууламж болон сүү, сүүн бүтээгдэхүүн дэх меламины хэмжээг шинээр тодорхойлдог боллоо. Түүнчлэн эмгэг төрөгч бактер болон тэдгээрийн хорыг 24-48 цагийн дотор 99 хувийн магадлалтай илрүүлдэг болсны зэрэгцээ өмнө нь 100 гаруй төрлийн бактер илрүүлдэг байсан бол 500-600 төрлийн бактерийг 8-24 цагийн дотор илрүүлэх боломжийг бүрдүүлэв.

АНУ-ын Цөмийн Энергийн Агентлагийн санхүүжилтээр 20.0 гаруй сая ам.долларын өртөгтэй сүүлийн үеийн цацрагийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг хилийн бүх боомтуудад 4 жилийн хугацаанд багтаан суурилуулах төслийг хэрэгжүүлж, Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд, Сүхбаатар боомтуудад 6.1 сая ам.долларын өртөг бүхий тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглалтад оруулав.

Говьсүмбэр, Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газарт конторын барилга, Булган, Шивээхүрэн, Даян, Ханх, Тэсийн шар үзүүр боомтод ажилчдын орон сууц, Замын-Үүд, Бичигт боомтод ариутгалын байр, Шивээхүрэн боомтод тусгаарлах байрыг бариулж, ашиглалтад оруулсны зэрэгцээ системийн хэмжээнд 8 автомашинаар парк шинэчлэл хийж, 300 гаруй компьютер, принтер бусад техник хэрэгслээр хангалаа.

Хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэв. Хүнсний аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, санхүүгийн зөрчлийг арилгах, дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах чиглэлээр хяналт шалгалтын ажлыг түлхүү хийх бодлого баримтлан төлөвлөлт, зохицуулалтын шуурхай арга хэмжээ авч ажилласнаар тодорхой үр дүн гарч байна.

Хүнсний аюулгүй байдал, үйлвэрлэл, үйлчилгээний хяналт

- Хүнсний тухай хуульд заасан “стратегийн хүнс” болох мах, гурил, үр тарианы чанар, аюулгүй байдалд болон архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаалалтад улсын хэмжээнд шалгалт хийв.
- “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил”-ийн хүрээнд хийсэн ажлын дүнг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэв.
- Улсын хэмжээний үр тариа, төмс, хүнсний ногоо хадгалах агуулах, зоориудад шалгалт хийж, бэлэн байдлыг хангуулав.
- 2008 онд үр тарианы 23 сортын 31753 га, төмсний 9 сортын 185.23 га, 9 нэр төрлийн хүнсний ногооны 7 сортын 6.75 га талбайд хянан баталгаа хийж өмнөх оныхоос сортын хянан баталгаа хийсэн талбайн хэмжээг 6179.9 га буюу 40 хувиар нэмэгдүүлж сортын цэвэр байдлыг хянаж баталгаажуулан улмаар хянан баталгаа хийгдсэн талбайгаас үр бэлтгэснээр тариалах үрийн чанарт ахиц гарлаа.
- Улсын хэмжээнд 52630.4 тонн хүнсний буудай, 12139.3 тонн тарих үр нөөцлөхөд хяналт тавьж ажилласнаар тариалах үрийн чанар 2007 онд 40 хувь нь стандартын шаардлага хангаж байсныг энэ онд 70 орчим хувьд хүргэв.
- БНХАУ-аас импортолсон 9 нэр төрлийн 236.6 тонн сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татаж худалдаалахыг түр хугацаагаар хориглосон бөгөөд нийт 259.0 тонн сүү, сүүн бүтээгдэхүүнийг БНХАУ-д буцаан ачилт хийлгэж, улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 48 тонн сүү, сүүн бүтээгдэхүүнийг хил дээрээс буцаав.

Эрүүл мэнд, боловсролын хяналт

- 25 нэрийн хуурамч болон стандартын бус эмийг илрүүлж, худалдаалахыг таслан зогсоов.
- Улсын хэмжээнд анги дүүргэлтийн талаар хийсэн удаа дараагийн шалгалтын дүнг үндэслэн бүх аймаг, нийслэлийн дүүргүүд сургуулиудын хамран сургах тойргийг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлж эхэлснээр анги дүүргэлт 2005 оныхтой харьцуулахад 2008 онд 36.4 хувь буурав.
- Ерөнхий боловсролын сургуулийг 11, 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар улсын хэмжээнд шалгалт хийв.
- Музейн сан хөмрөгийн улсын тооллогыг зохион байгууллаа.

Хилийн мэргэжлийн хяналт

- Хилийн мэргэжлийн хяналтын 11 алба, хэлтэс автомашинтай болж, иж бүрэн компьютер техник хэрэгслээр хангагдсаны зэрэгцээ нийт 23 боомтын 13 боомтод 2-12 айлын ажилчдын орон сууц баригдаж, Замын-Үүд, Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба түргэвчилсэн шинжилгээний аргын бага оврын лабораторитой болов.
- Хилийн мэргэжлийн хяналтын хамрах хүрээ 2003 онд улсын хилийн боомтод 50 гаруй, гүний гаальд 10 гаруй хувьтай байсныг 2008 онд улсын хилийн боомтод 90, гүний гаальд 50 орчим хувьд хүргээд байна.

Дэд бүтцийн хяналт

- Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот, 21 аймагт баригдаж буй барилга, авто зам, эрчим хүч, мэдээлэл холбооны барилга байгууламжийг шалгаж, барилга угсралтын ажлын чанар, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авав.
- Барилга байгууламжийн чанарт болон иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлж буй 18 барилгын болон мансардан барилгын үйл ажиллагааг зогсоов.

- Шинээр ашиглалтад орж байгаа авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоодог болгосноор зам байгууламжийн ажлын чанар сайжрах нөхцөлийг бүрдүүлэв.

- Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа цахилгаан шатанд техникийн хяналт хийж, ашиглалтын хугацаа дуусч байгаа 60 гаруй цахилгаан шатаас 30 гаруйг нь улсын төсвийн хөрөнгөөр шинэчлээд байна.

- Шилэн кабелийн сүлжээ, техник тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд явцын хяналтыг тавьж, байнгын ашиглалтад хүлээж авав. Ингэснээр 21 аймгийн 213 сум, суурин газрууд шилэн кабелийн сүлжээнд холбогдлоо.

Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт

- Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт 2007 оны эцсээр 51.7 хувь байсан бөгөөд 2008 онд 60 хувьд хүргэхээр ажиллаж байна.

- Химийн бодисоор бохирдсон хөрсийг саармагжуулж, хоргүйжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хийж, Төв, Сүхбаатар, Дорноговь аймгийн химийн бодисоор бохирдсон хаягдлыг зөөж тээвэрлэх, хоргүйжүүлэх ажлыг дуусгасан бөгөөд Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь аймгуудад үргэлжлэн хийж байна.

- Нийслэл, төвийн бүсийн аймгуудад хийсэн шалгалтаар 22.9 сая төгрөгийн мод, модон материалыг хурааж улсын орлого болгож, 8.1 сая төгрөгийн торгууль, 9.0 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоов.

Санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналт

- Санхүүгийн шалгалтаар 15.5 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөр ногдуулан 6.6 тэрбум төгрөгийг холбогдох байгууллага хүмүүсээр төлүүлэн улс, орон нутгийн төсөвт 1.2 тэрбум төгрөгийг оруулж, төрийн байгууллагын санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэв.

- Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын нийт ажиллагсдын 60 хувь хөдөлмөрийн гэрээгүй, 50 хувь нь нийгмийн даатгалд хамрагдалгүй эрх ашиг нь хохирч байгааг тогтоож, цаашид энэ чиглэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.

- Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аттестатчилах үзлэгийг улсын хэмжээнд зохион байгуулав.

Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэв. Тус газрын веб сайтыг технологи, агуулгын хувьд сайжруулж, “Веб сайтыг ажиллуулах журам” боловсруулан мөрдүүлснээр хяналт шалгалтын мэдээ, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэдэг боллоо.

Хилийн мэргэжлийн улсын хяналтын алба, Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба, Улаанбаатар хотын гүний гаалийн терминалиудыг холбосон мэдээллийн онлайн системийг 2009 оны 1 дүгээр улиралд ажилд оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Төрийн хууль тогтоомж, хяналт шалгалтын мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээллийн нэрэгслээр удаа дараа иргэд, олон нийтэд хүргэсэн бөгөөд хэвлэлийн бага хурлыг хэд хэдэн удаа зохион байгуулж, МҮОНРТ, UBS, ТМ телевизүүдтэй хамтран цуврал нэвтрүүлгүүдийг бэлтгэн явуулав.

Төрийн өмчийн бүртгэл, хяналт

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулав. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2008 оны 78, 167 дугаар тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг орон даяар зохион байгуулж дүнг хэлэлцэв. Үзлэг, тооллогонд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 934 хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 3458.2 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 3656 хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 673.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгө хамрагджээ. Тооллогод хамрагдсан нийт хөрөнгийн 83.7 хувь нь төрийн өмчлөлд, 16.3 хувь нь орон нутгийн өмчлөлд байна.

ОХУ-ын өмчлөлийн 7 орон сууцыг Монголын эзэмшилд хүлээн авав.

Монгол Улсын Ерөнхий сайд С. Баяр 2008 оны 4 дүгээр сард ОХУ-д айлчлахдаа Ерөнхийлөгч В. В. Путинтэй хамтран гаргасан Монгол-Оросын хамтарсан мэдэгдэлд үндэслэн Шархадны 1-р байр, Баянзүрх дүүргийн 15-р хорооллын нутагт байрлах 37а, 111, 114, 201, 202, 203 дугаартай нийт 7 байрыг Монголын талд үнэ төлбөргүй шилжүүлэх тухай ОХУ-ын Ерөнхий сайдын 2008 оны 1071 тоот захирамж гарсны дагуу ажлын хэсэг гарган байруудыг 2008 оны 11 дүгээр сарын 24-нд албан ёсоор хүлээн авлаа.

Засгийн газрын үндсэн зорилт

Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгав :

- ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж, түүнээс олсон орлогоос иргэдэд хүртээх;
- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр, тухайлбал, мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоогоор хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах;
- иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах;
- төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх.

**НЭН ТЭРГҮҮНД ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хуулийн нэр	Хариуцах яам, байгууллагын нэр
1.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	ЭБТЭХЯ, СЯ, Монголбанк
2.	Хадгаламжийн даатгалын тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл	Сангийн яам, Монголбанк
3.	Төвбанкны тухай	Сангийн яам, Монголбанк
4.	Банкны тухай	Сангийн яам, Монголбанк
5.	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах тухай	ЗТБХБЯ, СЯ, ХЗДХЯ, Монголбанк, СЗХ,
6.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай	ХЗДХЯ, СЯ, Монголбанк, СЗХ
7.	Үнэт цаасжуулах болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай	
8.	Орон сууцны барилгад хувь оролцуулах тухай	ЗТБХБЯ, ХЗДХЯ, СЯ, СЗХ
9.	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	СЯ, ХЗДХЯ, СЗХ
10.	Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын	СЯ, ХЗДХЯ, СЗХ

	тухай хуулийн төсөл	
11.	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	СЯ, ХЗДХЯ, СЗХ
12.	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль	СЯ, ХЗДХЯ, СЗХ
13.	Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	СЯ, СЗХ
14.	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай хууль	ХЗДХЯ, СЯ, СЗХ
15.	Худалдааны зохицуулалтын тухай хууль	ГХЯ, ХЗДХЯ, ХААХҮЯ
16.	Худалдааны хамгаалалтын тухай хууль	ГХЯ, ХЗДХЯ, ХААХҮЯ
17.	Демпингийн эсрэг хууль	ГХЯ, ХЗДХЯ, ХААХҮЯ
18.	Хоршооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	
19.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	СЯ, СЗХ
20.	"Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл	ХЗДХЯ, ЗГХЭГ
21.	Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	ХЗДХЯ
22.	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	ХААХҮЯ, СЯ
23.	Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын тухай хуулийн төсөл	БСШУЯ

--oOo--

Г А Р Ч И Г

ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ

- **Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт**
- **Эрүүл мэндийн салбарт**
- **Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт**
- **Санхүү, эдийн засгийн салбарт**
- **Зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт**
- **Мэдээлэл, харилцаа холбооны салбарт**
- **Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт**
- **Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт**
- **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт**
- **Батлан хамгаалах салбарт**
- **Гадаад харилцааны салбарт**

- **Хууль, эрх зүйн салбарт**
- **Мэргэжлийн хяналт, шалгалт**
- **Засгийн газрын үндсэн зорилт**
- **Нэн тэргүүнд шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай хууль тогтоомжийн жагсаалт**